



HOKKAIDO UNIVERSITY

Title	S. ドブチン著『モンゴルの経済状況がどのように継承されてきたのか』（1927年）：解説とキリル文字転写
Author(s)	エルデネバット, Da.; Erdenebat, Da.; 田淵, 陽子 他
Citation	北方人文研究, 15, 119-142
Issue Date	2022-03-25
Doc URL	https://hdl.handle.net/2115/83767
Type	data paper
File Information	15_08_Erdenebat_Tabuchi.pdf



[資料]

S.ドブチン著 『モンゴルの経済状況が
どのように継承されてきたのか』 (1927 年)
—解説とキリル文字転写—

An Introduction and Mongolian Cyrillic transcription of
“mongyul-un ed-yin jasay-yin bayidal, kerkin ulamjilaysayar
iregsen tuqai tobči debter” (“Brief note of tracing how the
Mongolian economy has evolved”), written by S.Dovchin in 1927.

Da.エルデネバット
(モンゴル国科学アカデミー歴史人類学研究所)
田淵陽子
(東北学院大学アジア流域文化研究所)

Da. ERDENEBAT
(Institute of History and Ethnology, Mongolian Academy of Sciences)
TABUCHI Yoko
(Historical Institute of the Culture in Asian River Basins,
Tohoku Gakuin University)

1. 史料解題¹⁾

本稿で紹介する、史料画像 138 枚、『モンゴルの経済状況がどのように継承されてきたのか』(以下、『モンゴルの経済状況』)²⁾ は、モンゴル人民共和国樹立 (1924 年) から三年目にあたる 1927 年に、モンゴル人閣僚 S.ドブチン (Санжийн Довчи, 1895–1941) がモンゴル経済の直面する課題と政策の方向性について記した、手書きモンゴル語文書である³⁾。

ドブチンは 1921 年モンゴル革命直後から政権入りし、陸軍省や外務省に勤め、1924 年以降、1939 年に拘束されるまでの間、財務省官房長、財務大臣、モンゴル銀行 (モンゴル商工銀行) 副総裁、のちに総裁、モンゴル人民共和国副首相という要職に就いた人物である。しかし、1930 年代の大規模なテロル時代、モンゴル政府や軍の多くの要人が、拘束後にソ連へ連行されて処刑されたように、ドブチンも 1941 年にモスクワで銃殺刑に処せられた。この時期、ドブチンのような専門家や閣僚

1) 「1. 史料解題」と「2-2. 史料解説 (和訳)」は田淵陽子が執筆した。「2-1. 史料解説 (モンゴル語)」と、「4. 史料キリル文字テキスト」は、Da.エルデネバットが執筆した。

2) 全画像は「北海道大学学術成果コレクション Hokkaido University Collection of Scholarly and Academic Papers (HUSCAP)」で閲覧及びダウンロードが可能である。URL は次のとおり。<http://hdl.handle.net/2115/83767>

は殆ど抹殺されたため、その経歴や歴史的役割については未解明の部分が多い。

モンゴル銀行は、ソ連政治局の主導のもと1924年に設立され、当初はミヘリマン、デイチマン、フェシュクといった人物がウランバートルへ派遣されていた（寺山2017：35、59-60、77）。ドブチンは銀行設立当初から要職に就いた古参の数少ないモンゴル人の一人で、1932年からはモンゴル人の初代総裁に就任した。ちなみに、ドブチンが1939年に失脚すると、後任として財務大臣兼モンゴル銀行総裁に就任したのは、23歳のYu.ツェデンバルであった。ソ連留学を終えたソ連寄り幹部として将来を嘱望されていたツェデンバルは、1952年、Kh.チョイバルサン元帥没後の後継者として首相に就任する。

1933年12月25日、ドブチンが、モスクワのクレムリンにてスターリン、ヴォロシロフらソ連首脳と交わした会談記録が残されている。21時から23時まで続いたこの会談には、東方勤労者共産大学（クートヴェ）留学を経てモンゴル人民革命党中央委員会書記、内務保安処長官などを歴任した、B.エルデブオチルも同席していた。ドブチンらは、スターリンから直々に、モンゴルの経済政策、宗教政策、教育政策などについて具体的な助言を受けていた様子が伺える（ダムディンスレンほか2005：58-63、寺山2017：224-231）。

ドブチンが財務大臣兼モンゴル銀行の要職にあった時期とは、国家予算強化のため、様々な重要措置がとられた時期と重なる。例えば、1924年モンゴル人民共和国からの全輸出の86%、外国からの輸入品87%は中国人の手中にあったといい、殆どが中国商人の影響下にあるという状態であった（二木ほか1998：235）。それゆえに、モンゴル銀行にとって自国貨幣の発行は重要な課題であった。また、「旧聖俗封建領主」の経済力も大きく、1924年当時、ジャス（寺院の財産）と合わせて全国総家畜数の約35%を所有していたという（同上）。

かかる状況に対して、1925年2月22日、モンゴル人民政府は国家貨幣トゥグリクの発行を決定し、通貨改革推進委員会を設立した。1925年には600万トゥグリク相当の紙幣の印刷をソ連に発注し、同年12月9日には流通に額面「一」「二」「五」「十」トゥグリクの紙幣が出まわった。トゥグリクの地位は徐々に強まり、1927年1月1日からすべての財政報告、予算、歳出入はもっぱらトゥグリクで算定されるようになり、次いで1928年4月1日からは、国内流通で使用される唯一の貨幣がトゥグリクと定められ、中国制銀貨や銀両は流通から完全に一掃された。1928年4月13日にはトゥグリクの交換価値を強化し、金本位制と決定した（二木ほか1998：245-246）。

本史料は、まさにこのような時期、国内の経済政策課題についてモンゴル人の視点から整理されたものである。具体的には、国家予算の整備、地方予算の統合、対外関税の徴収、牧民経営主に対する融資、軍役等旧制度の撤廃、統一税法など、ドブチンは、国民の生活基盤たる牧畜業発展のため国家があらゆる面において率先することを重要視するとともに、国家建設に不可欠な財政プランやインフラ整備、税法などの政策提言を記した。また、国民の財産たる家畜の正確な統計を取り、貧富の差に基づく税制制度の導入の必要性なども記している。

20世紀前半期、清朝の帝国統治から離脱したモンゴル社会が、ソ連の衛星国へと変貌する過程において、いかにして国家体制や経済体制を整えてゆこうとしたのか、本史料はその道程を示すものとなっている。と同時に、肅清されたモンゴル人閣僚の果たした歴史的役割についても光を当てるものである。（田淵陽子）

3) ドブチンに関するまとまった研究としては、[トヤー 2011]、[モンゴル国名誉回復組織委員会 2012] が挙げられる。

引用文献

- S.ダムディンスレンほか 2005 『モンゴルにおけるソ連共産党（ボルシェビキ）関係史料・第二巻』
ウランバートル。[С.Дамдинсүрэн нар эмхт. 2005 “Монголын тухай БХК(б) Н-ын баримт бичиг 1920-1952” (II боть) УБ.]
- S.トヤー 2011 「財務大臣ドブチン」Ch.ダシダワー他 2011 『モスクワで処刑されたモンゴル人指導者たち』ウランバートル、111-140 頁。(С.Туяа “Сангийн Яамны сайд С.Довчин” [Ч.Дашдаваа, С.Туяа. 2011. “Москвэд Цаазлагдсан Монголын Удирдагчид.” УБ., тал.111-140])
- 寺山恭輔 2017 『スターリンとモンゴル』みすず書房。
- 二本博史ほか訳・モンゴル科学アカデミー編著 1988 『モンゴル史 I』恒文社。
- モンゴル国名誉回復組織委員会 2012 『粛清被害者の伝記総集』第 13 巻、ウランバートル。
[Цагаатгах Ажлыг Удирдан Зохион Байгуулах Улсын Комисс “Улс төрийн хэлмэгдэгсдийн намтрын товчоон. Боть XIV.” УБ., 2012.]

2-1, 史料解説 (モンゴル語)

Бидний танилцуулах гэж буй энэ гар бичмэл нь Монгол улсын ШУА-ийн Философи, социологи, эрхзүйн (хуучнаар) хүрээлэнгийн философийн ухааны доктор, профессор Дуламын Дашжамцын (1930-2015) хувийн сан хөмрөгөөс олдсон түүхтэй.

Гар бичмэлийг ШУА-ийн Философийн хүрээлэнгийн (2015 оны нэршлээр) эрдэмтэн нарийн бичгийн дарга, философийн ухааны доктор (Ph.D), М.Золзаяа нь ШУА-ийн Түүх, археологийн хүрээлэнгийн (2015 оны нэршлээр) Орчин үе, бүс нутгийн судалгааны салбарын эрдэм шинжилгээний ажилтан, түүхийн ухааны доктор Да.Эрдэнэбатад ХХ зууны Монгол улсын эдийн засгийн шинжилгээний чиглэлээр судалгаа явуулдагийг нь харгалзан өгсөн болно. Энд түр азнаж, философийн ухааны доктор, профессор Д.Дашжамцын тухай бэсрэг намтрыг оруулья.

Тэрбээр 1958 оноос хойш Монголын түүх, түүхэн бие хүний намтар судлал, ёс зүй, нийгэм-улс төрийн сэтгэлгээний түүхийн чиглэлээр ном, товхимол 17, хамтын бүтээлийн бүлэг зүйл 18, өгүүлэл 100 орчмыг бичиж ОХУ, Япон, Куба, Болгар зэрэг оронд нийтлүүлжээ. Д.Дашжамц ШУА-ийн Түүхийн хүрээлэнд ажиллаж байхдаа эрдэмтэн С.Пүрэвжавтай хамтран 1921 оны Ардын хувьсгалын дараа хүрээ хийд, лам нарын асуудал хэр зэрэг цар хүрээтэй оршиж байсан, МАХН, төрөөс энэ талаар ямар бодлого явуулж хэрэгжүүлснийг архив, номын санд буй үлэмж материалыг уудлан судалж, «БНМАУ-д сүм хийд, лам нарын асуудлыг шийдвэрлэсэн нь» (1921-1940) гэсэн хамтын бүтээлийг 1965 онд хэвлүүлсэн нь эдүгээ ч судалгаанд өргөн ашиглагддаг. Профессор Д.Дашжамц нь ХХ зууны хоёрдугаар хагасаас хойших Монголын түүх, философи, ёс зүйн ухааны хөгжилд томоохон хувь нэмэр оруулсан төдийгүй ШУА-ийн Философийн хүрээлэнгийн үндэс суурийг академич Б.Ширэндэв, Ш.Бира, Ш.Нацагдорж, Ч.Жүгдэр нарын хамт тавилцаж, цаашдын хөгжлийн төлөө хүчин зүтгэсэн нэртэй эрдэмтэн байв.

Тус гар бичмэл нь Монгол улсын 17 (1927) оны 5 дугаар сарын 25-наар өдөрлөгдөж, “Монголын эдийн засгийн байдал хэрхэн уламжлагдсаар ирсэн тухай” хэмээх нэртэй бөгөөд зохиогчид нь С.Довчин, Чойлон⁴⁾ нар юм. Уг бичмэл нь муутуу цаасан дээр бичигдсэн, өргөн нь 19 см, урт нь 20.5

4) Хөвсгөл аймгийн Арбулаг сумын харьяат. Судар бичгийн хүрээлэнгийн нягтлан бодохоор ажиллаж байжээ.

см хэмжээ бүхий, 133 хуудастай болно.

Эл гар бичмэлтэй адил хувилбар буй эсэхийг сураглаж, эрдэмтэн судлаачдаас асууж лавлан, архивын сан хөмрөгт байгаа эсэхийг сурвалжлан үзээд хараахан ондоо эхийг илрүүлж чадсангүй.

Гар бичмэлийг зохиогчдын талаар цухас дурдая.

Санжийн Довчин (1895-1941):

БНМАУ-ын эдийн засгийг зузаатгах, арвижуулан батжуулах үйлсэд тод ул мөрөө үлдээсэн хүн бол санхүү, эдийн засгийн нэрт зүтгэлтэн С.Довчин юм. Тэрбээр Сайн ноён хан аймгийн Илдэн бэйлийн хошууны нутаг Есөн зүйл (одоогийн Өвөрхангай аймгийн Өлзийт сум) хэмээх газар 1895 оны 8 дугаар сард тайж Хасын хамжлага ард Санжийн хоёрдугаар хүү болон мэндэлжээ⁵⁾.

С.Довчин 12 настайгаасаа гэрийн сургалтаар боловсрол эзэмшин, 1908-1912 онд хошуу тамгын газар, аймгийн чуулганд туслах ба жинхэнэ бичээч түшмэлийн алба хаших болсноос (1913 онд Нийслэл Хүрээнд иржээ) эхлэн төрд зүтгэж (өөрийн хичээл зүтгэлээр орос хэлийг сурч, оросоор шаггүй ярьж ойлгодог байжээ), улмаар Нийслэл Хүрээний Хужиртбулан дахь Сайн ноён хан аймгийн цэргийн хороонд бичээч, дараа нь Цэргийн Явдлын Яаманд түшмэл, эх зохиох түшмэлээр 1914-1919 он хүртэл алба хашсан байна.



Үндэсний ардчилсан хувьсгал ялсны дараахан буюу 1921 оны 7 дугаар сарын 11-нд Цэргийн Явдлын Яаманд ерөнхий хэлтсийн эрхлэгчээр орж ажилласнаас шинэ Засгийн газарт зүтгэж, 1923 оны 3 дугаар сард Зүүн өмнөд хязгаарын цэргийг захирах сайд, 1923-1924 онд Гадаад Явдлын Яамны эрхэлсэн түшмэл, 1924-1926 онд Сангийн Явдлын Яамны эрхэлсэн түшмэл, 1926-1939 онд Сангийн Явдлын Яамны сайдаар ажиллахын хамт 1926-1930 онд Монгол банкны ерөнхий хорооны орлогч дарга, 1932-1939 онд жинхэнэ дарга, 1926-1935 онд БНМАУ-ын Ерөнхий сайдын орлогчоор ажиллаж байжээ.

С.Довчинг 1939 оны 2 дугаар сарын 11-ний 13 цагт улс төрийн хилс хэрэгт баривчилсан юм. ЗСБНХУ-ын Дээд шүүхийн цэргийн коллеги 1941 оны 7 дугаар сарын 5-ны өдөр ЗСБНХУ-ын эрүүгийн хуулийн 58-1 а, 58-7, 58-11 зүйл ангиар яллаж, ялын дээд хэмжээ - бүх хөрөнгийг нь хурааж буудан алах ял төлөвлөж (Тагнуулын ерөнхий газрын төв архив. Ф.4, ХН-30, Х-145), уг ялыг 1941 оны 8 дугаар сарын 17-нд гүйцэтгэсэн (Тагнуулын ерөнхий газрын төв архив. Ф.4, ХН-30, Х-145) тухай түүний хавтаст хэрэгт тэмдэглэжээ⁶⁾.

С.Довчин нь шинэ эргэлтийн бодлогыг дэмжиж, улсын сан хөмрөгийг хэмнэж санхүүг арвижуулан, ардуудын эдийн засгийн боловсролыг дээшлүүлэхэд чиглэсэн онол, аргазүйн талаар

5) С.Ичинноров. Санжийн Довчин сайдын эдийн засаг, улс төрийн байр суурь. УБ., 1994. т. 5

6) Цагаатгах Ажлыг Удирдан Зохион Байгуулах Улсын Комисс “Улс төрийн хэлмэгдэгсдийн намтрын товчоон. Боть XIV.” УБ., 2012. т. 128

олон арван өгүүлийг тогтмол хэвлэлд нийтлүүлсэн юм.

Үндэсний эдийн засгийн удирдлагыг улсын гарт төвлөрүүлэхийн тулд Монгол-Зөвлөлтийн хувь нийлүүлсэн Худалдаа аж үйлдвэрийн банкныг 1924 оны 6 дугаар сард байгуулж, 1925 оны 12 дугаар сарын 9-нөөс Монгол улсын анхны мөнгөн тэмдэгтийг гүйлгээнд оруулж, мөнгөний шинэчлэлт явуулж байсны дээр С.Довчин Сангийн Явдлын Яамны сайдын болон мөнгөний шинэчлэлт хийх Монгол улсын комиссын гишүүний хувиар, Монгол банкны ерөнхий хорооны орлогч дарга, даргын албыг 1926-1939 онд хашиж байсны хувьд банк, мөнгөний асуудлыг төр, засгийн өмнө эрхлэн хариуцаж байв⁷⁾.

Тэрбээр Сангийн Явдлын Яамны сайдаар томилогдон ажиллах үедээ (1927.05.25), бидний өгүүлэх “Монголын эдийн засгийн байдал хэрхэн уламжилсаар ирсэн тухай дэвтэр” буюу гар бичмэлийг өөрийн шавь Чойлонгийн хамт бичсэн байна.

Уг гар бичмэлийн агуулга нь:

1. Эдийн засгийн үндсэн бодлогын тухай
2. Улсын санхүүгийн байдлын тухай
3. Мөнгөний явдлыг шинэтгэн сайжруулах тухай
4. Орон нутгийн захиргааны газруудын санхүүгийн тухай
5. Малын ажлын тухай
6. Дэлхийн баялаг ба тариалан хадлангийн тухай
7. Тээх нэвтрүүлэх явдал ба аж үйлдвэрийн тухай
8. Тус улсын худалдааны байдал ба харилцан туслалцах хоршооны зорилгын тухай болно.

Сангийн Явдлын Яамны сайд С.Довчин нь шавь Чойлонтойгоо нэр хамтран бичсэн эл гар бичмэлийн гол ач холбогдол нь Монгол улсын эдийн засгийг зузаатгах бодлогод нэн хэрэгцээтэй салбаруудыг яаралтай хөрөнгөжүүлэх, боловсон хүчнээр хангах, худалдааг өргөнөөр явуулахдаа орон нутагт байгуулах хоршоодын эрхийг чөлөөтэйгөөр ардуудад олгож гүйцэтгүүлэх, санхүүгийн алдагдалыг бууруулахгүй байх, байгалийн баялагийг зүй зохистой ашиглах, аж үйлдвэрийг хөгжүүлэх, малыг өсгөн хамгаалах арга хэмжээг авах, гааль татварын бодлогыг системтэйгээр явуулахад онцгойлон анхаарахад оршиж байв.

С.Довчин тус гар бичмэлийг зохиох үед манай улсын санхүү эдийн засгийн салбарт нэгэн онцлог үйл явдал бий болсон нь Монгол улсад арилжааны хэрэгсэл болох “төгрөг”-ийг улс орны хэмжээнд хэрэглэж занших үйл явц хэрэгжин гүйцэж байсантай холбогддог.

Тэрбээр Монгол улсын Сангийн Явдлын Яамны сайдаар тохоогдоод ердөө нэг жилийг үдэж байхдаа улс орны санхүү эдийн засгийн бодлогыг арвижуулахад баримтлах үзэл баримтлал, чиглэлийг ийнхүү дэвтэрлэн үлдээсэн нь туйлын чухалтай юм. Эл гар бичмэлээс бид тухайн үеийн Монгол улсын эдийн засгийн амьдралыг таньж мэдэхээс гадна, тулгамдаж буй асуудлуудыг дэс дараалан багцалж, шийдвэрлэх арга замыг хайж байсантай танилцах болно. (Da.Erdenebat)

7) Улс төрийн хэлмэгдэгсдийн намтрын товчоон. Боть XIV. УБ., 2012. т. 80

2-2, 史料解説 (和訳)

本稿で紹介する『モンゴルの経済状況がどのように継承されてきたのか』という手書き文書（以下『モンゴルの経済状況』）は、モンゴル国科学アカデミー哲学・社会学・法学研究所（旧称）の、哲学博士 D.ダシジャムツ（Дуламын Дашжамц, 1930-2015）教授の個人収蔵品の中から発見されたものである。

この手書き文書は、科学アカデミー哲学研究所の哲学博士 M.ゾルザヤー（М.Золзая）氏によって、20世紀のモンゴル国経済研究に従事していた歴史学博士 Da.エルデネバット（執筆。2015年当時の科学アカデミー歴史学・考古学研究所の地域・近現代史研究部門研究員）に譲渡された。次に、ダシジャムツ氏について紹介する。

彼は1958年以降、モンゴル史、歴史人物の伝記、倫理学、社会政治思想史の分野で、17冊の出版物、18冊の共著、100本近くの論文を発表し、それはソ連、日本、キューバ、ブルガリアなどの国々でも紹介された。ダシジャムツ氏は、科学アカデミー歴史研究所に所属していた頃、歴史学者 S.ブレヴジャヴ氏とともにモンゴル人民革命勝利期の寺院や僧侶問題がいかなる位置づけにあったのか、モンゴル人民革命党政府がこの問題についてどのような政策を行っていたのかについて、アルヒーフや図書館の膨大な史料をくまなく調査し、『モンゴル人民共和国における寺院・僧侶問題の決定（1921-1940）』という共著を1965年に出版したが、これは現在もなお先行研究として広く引用されている。ダシジャムツ教授は、20世紀後半期におけるモンゴル史、哲学、倫理学の発展に大きく貢献したのみならず、B.シレンデブ、Sh.ビラ、Sh.ナツァグドルジ、Ch.ジュグデルらとともに、科学アカデミー哲学研究所の基盤を築き上げ、後進のために尽力した高名な研究者であった。

さて、この『モンゴルの経済状況』という史料には、「モンゴル国17（注：西暦1927）年5月25日」と日付が記されており、表題は『モンゴルの経済状況がどのように継承されてきたのか』、著者は「ドブチン」、「チョイロン⁸⁾」と記されている。実物は19cm×20.5cm四方の毛頭紙、総数133頁ある。筆者は、この手書き文書の複製の存在についてアルヒーフを調べ、研究者にも問い合わせたが、今のところ見つからない。

次に、この手書き史料の執筆者 S.ドブチン（Санжийн Довчин, 1895-1941）について紹介する。S.ドブチンは、モンゴル人民共和国の経済の強化発展において重要な足跡を残した、財政・経済の専門家である。彼は、サインノヨンハン・アイマグのイルデン・ベイセ旗にあるユスン・ズイル（現在のウブルハンガイ・アイマグ、ウルジート・ソム）という土地に、1895年8月、タイジ・ハスのハムジラガ（随丁）、平民サンジの第二子として生まれた⁹⁾。ドブチンは、12歳から地元で勉学をはじめ、1908-1912年、旗や盟の役所で書記や官吏をつとめ（1913年にフレー／現在のウランバートルにきて）、国政にたずさわ（ロシア語も習得した）、さらにフレーのホジルトボランにおけるサインノヨンハン・アイマグ軍属書記、後に、兵務省の官吏、書記官として、1914-1919年まで務めていた。1921年7月11日、モンゴル民族民主革命の勝利直後に兵務省の部長に任命され、革命新政权入りし、1923年3月に東南方面軍の管轄、1923-1924年外務省官房長、1924-1926年財務省官房長、1926-1939年財務大臣を歴任。1926-1930年モンゴル銀行副総裁、1932-1939年総裁を兼任。1926-1935年モンゴル人民共和国副首相を務めた。1939年2月11日13時、ドブチンは虚偽の罪に

8) フブスグル・アイマグのアルボラグ・ソム出身。典籍委員会にて会計の仕事を担っていた。

9) S.イチンノロブ1994『サンジーン・ドブチン大臣の経済的政治的役割』ウランバートル、5頁。

より逮捕された。ソビエト社会主義共和国連邦上級軍事法廷は、1941年7月5日、刑法58-1a、58-7、58-11条項の判決を下し（諜報局中央アルヒーフФ.4、XH-30、X-145）、極刑—すなわち全財産没収および銃殺刑とし、同年8月17日に刑が執行された（同上）と罪状ファイルに記録されている¹⁰⁾。

ドブチンは、新転換政策を支持し、国家財政の改革、国庫の増大、経済改革の理論や手法について数多くの出版物をまとめていた。

国民経済の主導権を国家に集約させるために、モンゴル・ソ連共同出資の商工業銀行（モンゴル銀行）を1924年6月に設立し、1925年12月9日よりモンゴル国初の通貨を流通させ、通貨改革を実施するなど、ドブチンは財務大臣、通貨改革推進委員会メンバー、モンゴル銀行副総裁あるいは総裁として、1926-1939年の在任期間、銀行や貨幣問題を政権において統括していた（肅清被害者の伝記集：80）。

そして、財務大臣総裁に在任中（1927年5月25日）、本稿で紹介する『モンゴルの経済状況』という手書き文書を、弟子（シャビ）のチョイロンとともに執筆した。


この手書き文書の内容は、次の八項目に分類されている。

- 1) 経済の基本政策について。
- 2) 国家の財政状況について
- 3) 貨幣流通の刷新について。
- 4) 地方行政の財政について。
- 5) 牧畜業について。
- 6) 天然資源と農地・牧草について。
- 7) 交通要路と商業について。
- 8) 我が国における商業の状況と協同組合の目的について。


財務大臣ドブチンが弟子チョイロンとともに執筆したこの手書き文書の意義とは、モンゴル人民共和国の経済力強化政策において、必要な部局に対して資金を投入し、適切な人材を配置し、商業を発展させるために地方における共同組合の権利を自由に国民に与え活動させる、財政損失から目をそらさず、天然資源を適切に利用する、工業を発展させる、家畜を殖やし保護する政策を立案する、関税政策などを秩序的に運用することを重要視していたという内容にある。ドブチンがこの手書き文書を執筆した時期というのは、モンゴル人民共和国の財政分野における重要な事業、すなわち国内の交易手段となる「トゥグルク」通貨を全国に流通させた時期と重なっている。

彼が、モンゴル人民共和国の財務大臣に任命されて一年ほど過ぎた時期に、国家財政の基盤強化のため、このように著作を残したことは大変重要な意味がある。我々はこの手書き文書を通じて、当時のモンゴル国の経済状況を知るだけでなく、直面していた問題を整理したうえで解決方法をいかに探っていたのかを知ることができるのである。（田淵陽子訳）


10) モンゴル国名誉回復組織委員会 2012『肅清被害者の伝記総集』第13巻、ウランバートル、128頁。

3, 史料画像サンプル¹¹⁾


(1)



(2)



(3) 1



(4) 2

11) 画像総数 138 枚。原本手書き頁総数 133 頁。() 内に画像番号、そのあとに原本頁数を付記した。

4, 史料キリル文字テキスト¹²⁾**Багш Довчин****МОНГОЛЫН ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ ХЭРХЭН
УЛАМЖИЛСААР ИРСЭН ТУХАЙ ДЭВТЭР****шавь Чойлин****ЭДИЙН ЗАСГИЙН БАЙДАЛ АМОЙ**

Эдийн засгийн үндсэн бодлогын тухай.

Монгол Улсын байдлыг зүйлчилсэн нь. Урьдах засгийн үед Монголын санхүү хэмээгч чухам ямар байдалтай байсан тухай.

Бидний монголчууд Чин улсын захиргаанд бүхий цагт, улс ардыг засах зэрэг улсын дээд эрхийг явуулах эрх огт үгүй бөгөөд цөм Манж-Хятадын захиргааны газрын заавар тушаалыг хүлээж агсан ба, орон (1)^{*}) нутгийн захиргааны хэрэг явдлыг өөрсдөө эрхлэн явуулж нэр буй боловч мөн тэр үеийн эзэрхэг засаг ноёд ба хутагт хувилгаад болон мөн тэдний талын захирагч бялдууч түшмэдийн эзэрхэг эрх сүрийн доор боолчлогдон явсан нь, аливаа албан хэргийн шийтгэвэр цөм тэдний хэмжээ үгүй эрх мэдэлд бүрэн агсны учраас ард түмэн нь улсын эдийн засаг хэмээгч чухам юу болохыг олж мэдэх ч байтугай, эрх барьсан эзэрхэг этгээдээс болов. Энэ тусгайлан бодлого тогтоосон зүйл үгүй ба, (2) ер манай Монголд төвийн санхүү хэмээгч огт байсан үгүй, учир юу хэмээвээс тус монголчуудыг удирдаж агсан Манж-Хятадын эрх баригчдын Монголын ард түмнийг элдэвт гэгээрүүлэн боловсруулж хүмүүжүүлэн тохинуулахыг огтхон ч эрхэлсэн газар үгүй, харин зүйл бүрийн аргаар мунхруулж харанхуй бүдүүлгээр агуулан байж тус Монголын газрын элдэв ашиг шимийг яс (3) чөмгөнд хүртэл мөлжихийг чухал бодлого болгосны харгаагаар эдийн засгийн бодлого ба санхүү зэргийг тогтоон явуулсан үгүйгээр үл барам ард түмнийг эзэрхэг ноён тайж нар ба хутагт хувилгаадын хамжлага шавь болгон хуваарилж захируулан мөн тэдэнд хэргэм зэрэг ямба цол пүнлүү цалин зэргийг олгож ард олныг захирах эрхийг үе улируулан явуулсан нь ард түмнийг (4) дарангуйлан эзэрхийлж мөлжихөд хялбар болгосон муу арга даруй мөний дээр тэдгээр эзэрхэг засаг ноёд нутагт хувилгаад болбоос тус тусын хамжлага шавийн зэрэг ардуудыг хувийн өмч хөрөнгө мэт үзэж мал адгуусан мэт боолчлон дарлах явдал туйлд хүрсэн ба тэдний эзэрхэг харгис нар элдэв албан татварыг цөм өөр өөрийн дур зоргоор явуулах төдий үгүй тэрхүү ноёд (5) баяд этгээд ба сан жасын мал хөрөнгийг эрхтэн дархтан хэмээн ялгаварлаж алба татварыг хэлтрүүлэх ба бас зарим хөрөнгөлөг этгээдүүдийг тэдний эзэрхэг ноёд, лам нар лугаа хөрөнгөнөө эрхээр холбогдолцон агсаар мөнхүү эзэрхэг нар буюу тэдний аянтал дагалдагч зусарч бялдууч нарт хээл хахууль өгөх зэрэг ба албан татвараас хэлтрэх ба, өгөвч өчүүхэн бага өгөх зэргийн муу зам (6) нээгдсэний учраас албан татварын аль ихийг жинхэнэ ядуу ба дунд ардууд хүлээж дэндэш үгүй дарлагдлыг амсаж байсан ба басхүү уг татварласан зүйлийг ер улс нийтийн аж ахуйг сайжруулан хөгжүүлэх буюу ард олныг эрдэм соёлд гэгээрүүлэн боловсруулах зэрэг ард түмэнд тустай хэрэгт

12) Монгол бичгээс кирилл үсэгт буулгасан Да.Эрдэнэбат.

*) 以下 () 内の数字は、原本の手書頁数を示し、頁最終単語の直後に挿入した。

зарцуулж элдэв садар самууныг үйлдэн хоосон жаргал цэнгэлийг (7) гол болгож байсан ба албан татвар оногдуулж хураах цаг хэмжээ тогтоосон үгүй буюу нийгэм тэгшийг олж явуулсан үгүй уг албан татвар нь ард түмэнд гэнэт аюул болж байснаар үл барам мөн тэр цагт хятадын нэр бүхий хэдэн пүүсэнд олон аймаг хошуудын түнш хэмээн нэрийдэхээр эрхийг барьсан эзэрхэгүүд лүгээ хуйвалдан ард түмнийг мөлжиж агсан бөгөөд тэдгээр түнш хятадууд нь чухам эзэрхэг засаг ноёд хутагт (8) хувилгаадын санхүү болж байсныг товчилбоос, орон нутгийн эрхийг барих эзэрхэгүүд хувийн эзэрхэгүүд, хувийн эзэрхэг зүйлүүд цөм тэдгээр түнш нараас тухай бүр бэлхнээ авч орон төлбөрийг ард олноос татварлан төлөх бөгөөд уул хятад нар болвоос өгөх зүйлийг үнэ зохион басхүү хэтэрхий хүү үржүүлэх ба авах малыг түүхий эд зүйлийг асар бага үнэ бодох төдийгүй уул зээлдүүлсэн мөнгөний үржсэн хүүг эхэд хамтатган (9) дахин хүү үржүүлэх зэргээр ард түмнийг яс чөмгөнд хүртэл ашиглан шимж асан суусаар эцэс улиралд өр ширэнд холбогдож хүнд бэрхийг хүлээсэн үгүй аймаг хошуу ба ард иргэн бараг үгүй болжээ.

Манж-Хятад нар болвоос өөрийн харьяат худалдааны пүүс иргэдийг Монгол газарт үлэмжхэнээр дэлгэрүүлж түүхий эд зүйлийг хямд үнээр авах ба бас тариачин үйлдвэрчин зэрэг нүүдлийн иргэдийг маш (10) үлэмжхэнээр Монгол газрын дотор нэвтрүүлэн оруулж атар газрыг дураар хагалбарлан тариалан үйлтгэх модыг хамаа үгүй сүйтгэх зэргээр тус орон нутгийн элдэв ашиг шимийг эзэрхийлэн ашиглаж хохируулсан явдлыг тоочиж барахгүй болой. Дараагаар бидний Монголчууд хэдий Манж-Хятадын гараас мултарч өөртөөн засах Автономит Засгийн эрхийг явуулсан хэмээвч улсын эдийн засгийн бодлогыг тогтоосон газар үгүй мөн төвийн санхүүтэй (11) байсан нэр буй боловч улсын орлого зарлагыг урьдаас төсөвлөж илүү дутууг мэдэх зэргийн чухал зүйлүүдийг огт хайхарсан үгүйн учир жилийн орлого зарлагыг ямар болсныг мэдэхгүйгээр үл барам улсын санхүүгийн явдлыг сайжруулах ба гааль түрээсний хэргийг сайнаар явуулах аж ахуйн явдлыг хөгжүүлэн бадруулах ард олноос татварлах аливаа зүйлийг хөнгөтгөх нийгэмчлэх хэмжээ журам тогтоох (12) зэргийг улсын эдийн засгийн үндсэнд холбогдон бүхий чухал хэргүүдийг төдийлөн сайнаар хөдөлгөн явуулсан үгүй бараг төлөв урьдын адил байсан бөгөөд уул санхүү нь хоосон байсан удаа ч цөөнгүй ба улсын цэрэг болон албан хаагчид цалин хэрэглэлийг хэд хэдэн сараар талбин олгож чадахгүй буюу гадаадад үлэмжхэн өртэй байсан амой. Үүнд улсын засаг захиргааны эрхийг нэгэнт гартаан (13) авсан атал тийнхүү эдийн засгийн байдлыг сайжруулж чадсан үгүй буй хэмээвээс улсын эрх баригчид нь цөм эзэрхэг засаг ноёд болон хутагт хувилгаад хэвээр байсны гайгаар молхи ардад олгох ашиг тусыг бодсон явдал үгүй харин ч зөвхөн хэдхэн биесийн жаргал цэнгэлийг гол болгох явдал туйлд хүрч албан нөхөх тухай харилцан аймаг, шавь хэмээх мэтээр тохой таталдан тэмцэлдэж агсаар (14) эдийн засгийн явдлыг чанартайгаар явуулж чадсангүй ба мөн ч тэр үед эзэрхэг засагт Орос улс ба Хятадын зэрэг гадаадын шунахай этгээд нар ямагт тус улсын ашиг шимийг булаан өрсөлдөж хүчирхэн эзэрхийлсэн гэм шалтгаан их л буй мэт бас дараа гамингийн этгээд засгийн эрхийг булаан эзэрхсэний дараа урьд Автономит Засгийн үед эдийн засгийн тухай бага сага (15) үүсвэрлэн явуулсан зүйлүүдийг устгаснаар үл барам тэд хэмээвээс ард түмнийг ноолон дарлаж тус орон нутгийн ашиг шимийг хэвээр мөлжих замыг нээгдүүлэн Монголчуудыг нэгэнт эрхэндээ дахин оруулсан болох нь манай Монголын эдийн засгийн явдлыг юу сайжруулахыг оролдох ажээ. Учир иймийн тул нүүдлийн иргэдийг үлэмжхэнээр оруулан газар орныг эзлэх зэргээр ашиг шимийг мөлжин хохируулах явдал урьдаас (16) нэн үлэмжхэн болж туйлд

хүргэхийг завдсан бөлгөө. Дараа хэдийгээр гамин цэрэг ангийг тус орноос хөөн зайлуулж Автономит улсын Засгийг дахин босгомой хэмээн мөрөөдсөн боловч тэр явдлыг Зөвлөлийн засагт Орос улсын газар оронд хөл зогсох газар үгүй болон зугатаасан цагаан намын муу хулгай барон Унгерн харгис Японы зэрэг гадаадын шунахай бодлогот этгээдийн (17) тусламж зааврыг гүйцэтгэн явуулсан хэрэг болох нь түүнд Монгол ард түмний ашиг тусыг бодож улсын аж ахуйг хөгжүүлэн эдийн засгийн явдлыг сайжруулах санал өчүүхэн ч үгүй хэмээх ч байтугай тэр цаг болвоос дэлхий дахинд алдаршсан шунахай этгээдийн гар хуруу нэгэнт манай Монголын газар оронд хүрч ирсэн үес мөн хэмээвээс зохих бөгөөд ард түмний туйлын дарлагдал хохирлыг (18) нь маш холгүй болсон билээ. Харин ч ард түмэн үүрдийн зол завшаан ба үгээгүй ядуу үйлдвэрчин хөдөлмөрчин ардын хувьсгалын ач гавьяагаар ард олон гал усны гашуун зовлонг онц үзсэн үгүй амой. Барон Унгерн бээр зорьсон хэргийг гүйцэтгэн явуулахуйд эрхбиш санхүүгийн зүйл чухал хэрэгтэй учир баталгааны тэмдэгт цаас хэвлэн гаргаж зарцуулсан нь уул (19) цааз хатуу бодлого үгүй хоосон нэрийдлээр үүсгэсэн бөгөөд тэр даруй тогтоосон үнэ нь буурах буюу хуурамчаар үйлдэгдэн гарч ард олны хөрөнгийг хохируулсан явдал багагүй болмой.

Багш Довчин

Ардын Засгийг байгуулснаас нааш эдийн засгийн бодлогыг хэрхэн тогтоон явуулж буй тухай. Байцааваас эдийн засаг хэмээгч улс төрийн (20) мандах мөхөхөд гүнээ холбогдсон туйлын маш чухал зүйл даруй мөн бөгөөд энэ тухай эрхбиш тусгайлан бодлого тогтоон явуулахгүйгээр үл болох үүнд эдийн засгийн бодлого тогтоон явуулахдаа энгийн хөрөнгөтөн хөгжүүлэх үгүйг чухал болгомой. Учир юу хэмээвээс манай Монгол хэзээнээс бусад гадаадын хүчирхэг улсуудын адил өдий төдий хөдөлмөрчний хүчийг хэрэглэж ашиг эрмэлзэх ихээхэн хөрөнгөтөн үгүй хэмээж болох (21) боловч хэрдээ тав арван хөдөлмөрчний хүчийг үнэлэх хөрөнгөлөг этгээд байж болмой.

Үйлдвэрийг гол болгомой хэмээвээс төлөв малын ажил мөн тэдний их төлөв нь урьд албан татвар төлдөггүй буюу ард олныг ил далд элдэв арга хэрэглэж хөрөнгөжсөн шар хар харгисууд болох ба энэ нь хэдий жинхэнэ аж үйлдвэрийг эрхэлсэн хөрөнгөтөн бус боловч даруй хөрөнгөлөг (22) ёсны төлөвтэй ажил хэмээж болох тул ийм явдал цаашид хэвээр хөгжих аваас ард түмний ашиг тусыг хамгаалах ба эрх чөлөөг хөгжүүлэх явдалд хортойгоор үл барам энгийн хөгжсөнөөр улсын аж ахуйн явдлыг сайжруулах ба ард олны ашиг тусыг хамгаалж хэрхэвч чадах үгүйн гэрч нь тэд цөм тус тусын ашиг завшааныг эрхлэхийн учир буюу тиймийн тул улсын худалдааны ба аж ахуйн (23) зэрэг чухал чухал зүйлүүдийг цөм улсаас эрхлэн удирдах ба ард нийтийн байгуулсан хоршоо мэтийн газраас эрхлүүлэн явуулах нь туйлын чухал болох бөгөөд нийт эдийн засгийн тухай бодлого ямар болохыг зүйлчилсэн нь:

Нэг. Улсын гадаад худалдааны явдлыг зүй зохисоор үзэн улсын онц эрх болгон явуулах ба санхүүгийн зэрэг бүх улсын эдийн засгийн явдлыг улсын Засгийн газраас удирдан явуулж (24) хөгжүүлэн улс төрийн мандах дэвших явдалд тустай болговоос зохимой. Хоёр. Тус улсын эд хөрөнгийн үндэс болох малын өсгөвөрийн ажлыг сайжруулан хөгжүүлэх явдлыг бүх улсаар санаа талбин оролдвоос зохимой. Учир нь малын ажлын сайн муугийн харгааг тус улсын элдэв аж үйлдвэрийн явдалд холбогдох баймой. Гурав. Эдийн засгийн тухай хэрэг явдлыг эрхлэн гүйцэтгэх (25) газруудыг сайтар зохилдуулан тогтоож идэвхтэй сайнаар явуулахыг чухал болгох. Дөрөв.

Малаас гарах түүхий эдийн зүйлийг улсын дотор боловсруулан ажиллах зэрэг аж үйлдвэрийн явдлыг хөгжүүлэх,

Тав. Дэлхийн баялагийн зүйлийг ашиглах явдлыг хөгжүүлэх. Зургаа. Гадаадын эзэрхэг харгис этгээдийн эзэрхэн бүхий цагт Монголын зарим нэгэн газар усыг колони болгон эзэлсэн ба, дахин тэр мэт булаан өнгөлзөхийг устгахын (26) дээр улсын дотор хэрэглэх тариа будааны зүйлийг дотроо бэлтгэн гүйцэтгэвээс зохих учир тариалангийн ажлыг өөрсдөө эрхэлж хөгжүүлбээс зохимой.

Долоо. Ой модыг ашиглах ан гөрөөс агнах загас барих зэрэг газар усны баялагийг ашиглах явдлуудыг эмхтэй дүрэмтэйгээр явуулах. Найм. Тусгайлан дотоод худалдааны явдлыг улсын Засгийн газраас эрхэлж данслан засах мөн улсын доторх худалдааг улсын сан ба хоршоо зэргийн (27) ард нийтийн байгуулсан газруудаас эрхлэн гүйцэтгэхийг туйлд хүргэхийн хамт хувийн худалдаа ба хувийн мөнгө гүйлгэх хөрөнгийг доройтуулахыг эрхлэх. Ес. Харилцан туслалцах хоршооны явдлыг туслан хөгжүүлэхийг эрхлэн сайжруулж жинхэнэ хоршооны замд оруулж.

Арав. Худалдааны явдалд чухал хэрэглэгдэх жин хэмжүүрийг нэгтгэн тогтоож ард олны завсраас хонжих мөлжих гэмийг ариутгах. Арван нэг. Цахилгаан утас тавих хөөрөг (28) тавих зам засах зэргийн харилцан нэвтрэлцэх явдлыг боловсронгуйгаар сайжруулан гүйцэтгэх.

Арван хоёр. Гадаад улсын мөнгө зоос гүйлгэн хэрэглэсний улмаас худалдаа ба мөнгө сангийн явдалд ард олны мөлжигдөх гэмээс устгахын учир өөрийн мөнгө зоосыг гаргаж хэрэглэх. Арван гурав. Тус улсын доторх хүн ам хөрөнгө малын үнэн тоог сайтар тодорхойлон мэдэж улсын аливаа засгийн (29) бодолхийх хэрэгт баримтлал болгох ба, буурай чадалтайг нь мэдэж аливаа үүргийг тэгшлэн хуваах мөн албан татварыг хөрөнгөний зузаан нимгэнийг харгалзан улмаар өсгөн ногдуулах басхүү уг татварлах албыг нэгтгэн хураах цаг хэмжээг тогтоох.

Арван дөрөв. Ардын эрүүлийг хамгаалах ба ариун цэврийг сахих эрдэм боловсролыг хөгжүүлэх явдлыг чухал (30) болгох бөгөөд улсын хүн ардын тоо олон энх мэнд эрдэм боловсролыг хөгжүүлэн чадваас түүн дэх улсын хөрөнгө арвин зузаан болмой.

Арван тав. Урьдах эзэрхэг харгисын үед зарим нэгэн хүн ба албаны газраас олны хөрөнгийг яаж гадаадын эзэрхэг шунахай лугаа хуйвалдан байгуулсан өр шир болвоос улсын ба ард олны аж ахуйд маш хорлолтой учир эл өрийн үлдэгдлийг бүрнээ төлүүлэхийг хэрэгсэхгүй болгон (31) устгасан ба бас аль нэгэн этгээдийн байгуулсан өрийг ард олонд халдаан төлүүлэхээр суртлыг устгасан гэнэ.

Улсын санхүүгийн байдлын тухай

Улс төрд санхүү хэрэгтэй буй хэмээвээс ямар нэгэн улс, улс төрийн аливаа хэргийг гүйцэтгэн явуулахад санхүү маш чухал хэрэгтэй бөгөөд улс төрийн явдал нь санхүүгийн явдлаар арвин зузаан болвол аяндаа хөгжин сайжрах ба хэрвээ хөрөнгө хомс бага болвол дутагдах (32) гачигдах зэргийн боогдолтой явдал үлэмжхэн болмой. Тиймийн тул санхүү нь чухамхүү улс төрийн хөгжин дэвших явдалд холбогдсон туйлын чухал зүйл мөн. Үүнд манай улс анх 11 дүгээр онд ардын засгийг байгуулах цагт урьдах засгийн үеийн санхүүгийн зүйл хэмээх юмгүй хоосон буурайг залгамжлан авсан болох нь хэргийг явуулахад санхүүгийн зүйл хомсдож их л гачигдалтай байсан үе буй боловч ард олноос алба татварлах явдлыг чухал (33) болгосонгүй гагцхүү улсын сан хураах аливаа орлогын зүйлийг маш идэвхтэйгээр явуулан басхүү зарлагыг арвилан хэмнэх зэргээр арга эрж явуулахыг эрхэм чухал болгосоор байсан нь уг хэрэг явдалд төдийлөн онц боогдолтой зүйл

гарсангүй болой.

Манай улсын санхүүгийн бодлого болвоос санхүүгийн хэргийг тус улсын эдийн засгийн бодлого ба улс төрийн зорилгод нийлүүлэн явуулах басхүү орлого зарлагыг эрхбиш хэрэглэх (34) жилийн урьд төсөвлөн бодож, данс үйлдэн улсын бүх орлого зарлагын тоо хичнээн болох зэргийг эртнээс төсөвлөн мэдэж аливаа явуулах хэрэгт боогдол дутагдалгүй болгохыг хичээх улсын орлогыг бат бэх болгож зарлагыг эрхбиш төсөвлөснийг баримтлан нарийн чандаар зарцуулах мөн орлого зарлагын тайлан данс хийж тогтоосон хэмжээнд шударгаар гүйцэтгэж нийт улсын орлого зарлагын тухай данс харааг нарийн тодорхой болгон сайжруулах ард олноос (35) хураах албан татварын тухай дүрэм хэмжээ тогтоож ёсчлон явуулах улсын орлогыг арвижуулахын учир санд хураалгах шинэ зүйлүүдийг олгох тусгайлан гааль татварын хэргийг сайжруулах банкны хэрэг ба мөнгө зоос гүйлгэх зээлдүүлэх зэрэг явдлыг эмхтэй болгох зэргийн чухал зүйлүүд болмой.

Санхүүгийн зүйлийг чухам ямар хэрэгт зарцуулмуй хэмэвээс улс төрийн гүйцэтгэн явуулах ямар нэгэн хэрэгт заавал санхүүгийн зүйл холбогдмой. Жишээлбээс улсын олон албаны газруудын орон сууц ба (36) албан хаагчдын цэвэр тэжээл бичгийн хэрэглүүн зэргийг бэлтгэн гүйцэтгэх ба улс төрийг хамгаалах цэргийн явдал ардын эрүүлийг хамгаалах ядуусыг тэтгэх ард түмнийг эрдэм соёлд боловсруулах аж ахуйн явдлыг сайжруулан боловсруулах зэрэг зүйл цөм багтах баймой.

Санхүүгийн зүйлийг зарцуулахад эрхбиш тогтсон дүрэм журам байваас зохих үүнд зарлагын зүйлийг төсөвлөхөд долоон анги болгож бичмой. Нэгдүгээр анги нь: албан хаагчдын цалин хэрэглэл (37), хоёрдугаар анги нь: бичгийн хэрэгслийн зүйл, гуравдугаар анги нь: орон байшингийн зарлага, дөрөвдүгээр анги нь: хогшил авах сэлбэх засах зарлага, тавдугаар анги нь: баяр ба зочдын зарлага,

Зургаадугаар анги нь: дээр нэр зааснаас бусад элдэв зүйлийн зарлага, долдугаар анги нь: бүх зарлагын дутагдсаныг нөхөх тухай магадлашгүй хэмээх зарлага болох бөгөөд бүх орлого зарлагын явдал болвоос улсын чухал зүйлүүдийн нэг нь даруй мөн болох тул энэ (38) тухайг улсын хуралд батлуулан явуулмой. Олон албаны газрууд сангаас мөнгө авч зарцуулахад энэхүү төсөвлөсөн дансны зүйл тутамд заасныг нь болвоос тусгай үнэмлэх бичиг хүргүүлээд авч болмой.

Түүнээс бус нэгэн зүйлд төсөвлөсөн мөнгийг нөгөө зүйлд дураар шилжүүлэн зарах эрх үгүй. Заавал Сангийн яам, Улсын хянан байцаах газрын зөвшөөрлийг авмой. Нэгэн газар нөгөө (39) газрын төсөвлөсөн мөнгөнөөс зарцуулах чухал хэрэг тохиолдох буюу төсөвлөснөөс ангид чухал зарлага гарах ахул заавал Засгийн газар батлуулмой.

Ер санхүүгийн зүйлийг ард олонд тусгүй зүйлд зарцуулахгүйг их л чухал болгодог учир нь улсын санхүү байгуулсны хэрэг болвоос гагцхүү улс төрийн ба ард түмний хэрэгт зарцуулахын (40) тулд бөлгөө. Хэрвээ санхүүгийн зүйл, олон газрын тус тусын хэрэгт дураар авч зарцуулваас нэгэн бодлого зам үгүй болмой.

Гаалийн тухай болвоос, аливаа дотоодоос гарах зүйлийн дотор хэрвээ тус улсад боловсруулан буй зүйл байваас гаалийг ихээхэн тогтоомой. Учир нь аж ахуйн боловсролыг хөгжүүлэх ба гадаадад гарч боловсруулан эгэж ирэхэд үлэмж үнээр (41) худалдан авч гадаадын худалдаачинд хэтэрхий мөлжүүлэх үгүйн бодлого буюу бас гадаадын газар чухал хэрэглэгдэх ангийн үсний зэрэг зүйлд ихээхэн гааль тогтоомой. Малын гаалийг бас ихээхэн тогтоомой. Учир нь малын үржлийг хөгжүүлэх бодлого болой.

Гадаадаас ирэх зүйлийн дотроос архи тамхины зэрэг буюу гоёмсогийн зүйлээс ихээхэн гааль авмой. Энэ нь ард олонд жинхэнэ чухал хэрэглэгдэх зүйл бусын учир болой (42). Ард түмний эрхбиш чухал хэрэглэгдвээс зохих бүдүүн бараа цай идээ уух зүйлээс бага авмой. Учир нь ард түмний чухал хэрэглэгдэх зүйлийг элбэг болгохын бодлого бас ажил боловсролд тустай машин, тогоо зэргээс бага авах зэргээр хэдэн анги болгомой.

Бас дотоод худалдааны гааль болвоос ард олонд ихээхэн боогдолтой болох учир зүй зохисыг үзэж хэлтрүүлэн ардын чирэгдлийг хомсотгомой. Татварын тухай болвоос аливаа худалдаачнаас авах бөгөөд учир нь санхүүг арвижуулах ба улсын доторх бүх худалдааны (43) гүйлгээ зэрэг зүйлүүдийг мэдэх нь чухлын дээр хувийн ба гадаадын худалдааны явдлыг хөгжүүлэхгүйн бодлого болмой. Бас ой мод ан гөрөөс загас тариалан хадлангийн зэрэг баялагийн зүйлээс түрээс хураах явдал болвоос уг зүйлүүдийг хамгаалан ашиглахын тул болой.

Ард олны албан татварын тухай болвоос дээр эдийн засгийн бодлогод дурдсан тийн авч тусгайлан дүрэм гаргуулан буйн гол төлвийг дурдваас (44) ядууг нь хөнгөтгөх баянаас нь өсгөн татах хураах цагийг тодорхойлох орон нутгийн эрх баригчид хэзээ ч хамаа үгүй дураар алба татахыг зогсоох бас бүх татварыг нэгтгэн ногдуулж албан үүргийн явдлыг данслан хохирол завшлийг нэгэн болгохын учир болой.

Бас өртөөний тухай олон ардын үүрэг болгон явуулахыг өөрчлөх бодлого буй. Ер улсын сангийн орлогын их төлөв нь энэ хэр гаалийн зүйлд итгэжээ. Энэ нь гадаад дотоодоос ирэх гарах худалдааны зүйл болох бөгөөд цагийн аясыг дагалдах зэргийн тогтвортой (45) баримт үгүй явдал буй нь төдий л баттай орлого хэмээж үл болмой. Тиймийн тулд газар дэлхийн баялагийг хөгжүүлэх ба аж ахуйн явдлыг сайжруулан боловсруулах зэргээр улсын орлогыг бат болгохыг хичээвээс зохимой.

Довчин

Мөнгөний явдлыг шинэтгэн сайжруулах тухай

Байцааваас аливаа гүйлгээнд хэрэглэх мөнгөний зүйл болвоос ямарч улсад чухал хэрэгтэй болох нь жишээлбээс улс төрийн аливаа гүйцэтгэн явуулах хэрэг зүйлд заавал мөнгөний явдал холбогдох бөгөөд санхүүгийн зүйлийг гүйцэтгэх ба нэн ялангуяа худалдааны (46) явдал аж ахуйн хэрэгт маш чухал хэрэглэгдэх баймой. Үүнд ямар нэгэн улс энэхүү мөнгөний явдалд хэрвээ гадаад улс нь хэрэглэх аваас уул мөнгөний үнэ ханш ба түүнийг хэрхэн явуулах эрх бодлого цөм тэрхүү улсын бүрэн эрх мэдэлд байх учир уул мөнгөний явдал нь улсын түгшүүртэй амгалангийн байдалд гүнээ холбогдох бөгөөд, алдах гэм маш үлэмжхэн болох төдийгүй бас ч тэрхүү мөнгийг гаргасан улс чадах чанад хэрэглэх бүхий газрын аливаа ашгийг уул мөнгө зэргээр зүйл бүрийн арга хэрэглэн (47) мөлжих явдал эрхгүй тохиолдох нь магад болох ба тийнхүү гадаад улсын зоос мөнгийг гүйлгэн хэрэглэсний гэм уршигийг гэрчилвээс уул мөнгө гаргасан улсад гэнэт дайн байлдаан үүсэх буюу эсвэл өөр ямар нэгэн учраас тэр улсын аж ахуй явдал сүйдэн санхүү нь буурах муудах аваас уул цаашид мөнгөний үнэ буурах зэргээр их л тогтворгүй болох бөгөөд тэрхүү явдлын уршгаас үнэ цаас мөнгийг хэрэглэн (48) зарцуулж бүхий газарт барааны үнэ нэмэгдэх улсын орлого хомсдох зэргээр чанад улсад болж буй зүйлүүдийг нэгэн нэгнээр дамжин ирж тохиолдомой. Жишээлбээс урьд эзэрхэг засагт Орос улсын мөнгөний тэмдэгт цаасыг манай Монгол газар маш үлэмжхэнээр дэлгэрч мөн түүний үнэ нь ард түмэнд бат сайнаар итгэгдэн явж асан нь дараа Европын их

байлдааны дашрамд мөнхүү цаасны үнэ ихэд буурсаар сүүлийн үед аливаа гүйлгээнд огт хэрэглэгдэхгүй болсон бөгөөд (49) үүний уршгаас манай Монголын олон түмний хохирол гарзсанаас барахгүй болой. Учир иймд ард түмнийг гадаадын эзэрхэг түрэмгий нарын шунахай мөлжигдлөөс ангижруулах явдалд энэхүү мөнгөний хэрэг туйлын чухал холбогдох учир, аливаа гүйлгээнд хэрэглэх мөнгөний зүйлийг өөрсдөө үйлдэж бэлтгэн зарцуулахад эрхбиш чухал болох бөгөөд, Засгийн газраас өөрийн үндсэн мөнгийг гаргаж зарцуулахад тэмдэгт цаас гаргах эрхийг банканд олгосон ба, мөн улсын мөнгөн төгрөг үйлдэж (50) зарцуулахаар тогтоосныг дагаж мөнгөн төгрөг ба тэмдэгт цаасыг түгээн гаргаж зарцуулснаас нааш эдүгээ нэгэн жил илүү болжээ.

Энэ завсар бүх гаргаж зарцуулсан банкны тэмдэгт цаас 3 сая илүү мөнгөн төгрөг нэгэн сая гаруй болсон нь Монгол газрын аливаа гүйлгээнд явж мөнгөний зүйлийг арван сая янчаан хэмээж бодвоос, арван хувийн дөрвөн хувийг өөрийн мөнгө зоосоор гүйцэтгэсэн болох бөгөөд, энэ нь гадаад мөнгө зоосыг хэрэглэх мөлжих гэмийг ангижруулах явдалд их л дөхмийг олж буй (51) хэмээвээс болно. Үүнд уул мөнгө төгрөг ба тэмдэгт цаасыг хэд хэдэн дэвсгэрээр гаргасныг дурдваас цаас нь 100, 50, 25, 10, 5, 2, 1-т болох ба мөнгө болвоос нэгэн төгрөгөөс 50, 20, 15, 10 мөнгө хүртэл, зэс зоос болвоос 5 мөнгөөс 1, 2 мөнгө хүртэл тус тус гаргасан амой.

Үүний дотор их төлөв нь тэмдэгт цаас болох бөгөөд, зэс ба цагаан мөнгө нь задлах жижиглэхэд чухал хэрэглэгдэх амой. Ер тэмдэгт гаргаж зарцуулсны ашиг тус юу болохыг дурдваас метал мөнгөнөөс цаасан мөнгө нь ачих зөөх тоолох хадгалахад амар хялбар болохыг хэн хүн мэдсээр болох (52) бөгөөд, жишээлбээс таван мянган төгрөгийг тээх аваас бараг тэмээний ачаа болмой. Хэрэв мөнгөн тэмдэгт цаас болохул нэгэн хүн хэд хэдэн түм бумыг биендээ авч явж болно.

Тиймийн тул, улсын дотор цөм биеэр мөнгө төгрөгийг зарцуулах аваас элдэвт төвөгшөөл бүхийн дээр ачих тээхэд үнэ хөлс үлэмж ихээхэн орох учир худалдааны бараа юм үнэ нэмэгдэх зүйл буй. Бас металаар хийсэн мөнгийг нааш цааш зөөх тээх ба, харилцан өгч авалцахад элэгдэх хорогдох нь багагүй бөгөөд энэ нь улсын (53) санд хохирол үлэмж болмой. Ер алт мөнгө зэрэг үнэ бүхий металыг улсын санд хураан хадгалваас зохих учир дан ганц алт мөнгө төгрөгийг цутгаж гаргах аваас уул төгрөгөөс үлэмжхэнээр гадаадад гарах ахул эгэж ирэхгүй болохол улсын баялаг хорогдох зэрэг үл зохилдох явдал буй.

Тиймийн тул мөнгөний тэмдэгт цаас гаргаж зарцуулах нь чухал баймой. Үүнд цаас гаргаж зарцуулахдаа хэрвээ тус улсын доторх гүйлгээнд хэрэглэгдэх мөнгөнөөс хэтрүүлэн гаргаваас үл болох (54) нэгэн зүйл буй. Юу хэмээвээс хэрвээ хэтэрхий үлэмжхэнээр гаргаваас худалдааны ба, зах зээлийн цаас үлэмждэж үнэ гэм буй бас ч цаасыг гаргахдаа үнэ бүхий метал зэрэг зүйлээр батлах хэрэгтэй. Үүнд гадаадын үй олон улсын уул гаргасан цаасны зуун хувийн арван таван хувиас хорин таван хувь хүртэл алт мөнгө зэрэг эрдэнийн зүйлээр бусдыг үнэ бүхий вексель хэмээх өр төлөх баталгааны бичиг ба элдэв бараа мөн барааны баримт бичиг зэрэг зүйлээр баталдаг хэмээх бөгөөд манай улс болвоос Засгийн газраас тогтоосон нь (55) 25 хувиас доошгүй хатуу эрдэнийн зүйлээр баталваас зохимой, хэмээн заасан боловч энэ хэр харьяат банкнаас гаргаж зарцуулсан цаасны баталгаа бүхий алт, мөнгөний зэрэг үнэ бүхий эрдэнийн зүйл хэмээвээс уг гаргасан цаасны 100 хувийн 67 хувь болох нь чухамхүү бодитой хэмээвээс зохих бөгөөд энэ нь тус улсын эдийн засгийн явдлыг хөгжүүлэн бадруулах хэрэгт туйлын бат суурийг тогтоож буй хэмээхээр үл барам гадаадын зоос мөнгийг даруй гүйлгэн (56) хэрэглэхгүй болгох явдалд асар холгүй болмой. Тиймийн

тул, энэхүү мөнөөхөн явдлыг шинэтгэн сайжруулах хэрэгт нийтээр чухал болгон үзэж санаа тавин оролдвоос зохих туйлын чухлын нэгэн мөн хэмээмүй.

Орон нутгийн захиргааны газруудын санхүүгийн тухай

Байцааваас орон нутгийн газруудад байгуулсны зорилт болвоос өөр өөрийн харьяат аймаг хошуу ба сум аравны зэрэг захиргааны газруудын аливаа явуулах албан хэргийг гүйцэтгэхэд чухал нөхцөл болмой. Жишээлбээс ард түмнийг эрдэм соёлд (57) боловсруулах орон нутгийн хамгаалан сахих элдэв ажил үйлдвэрийг хөгжүүлэн сайжруулах ард олны зовлон зүдгүүр ба ашиг тус явдлыг хянан шийтгэх зэрэг хэргүүд болох бөгөөд, үүнд аймаг хошууны санхүүгээс арвижан чадаагүй тэр дээр улсын элдэв орлогыг түүгээр орон нутгийн газраар хурааж мөн хураасан гааль татвар түрээс зэргийн зүйлээс дүрмд заасан ёсоор шимтгэл хоцоргохоос бусад зүйлээс орлогод төдийлөн өгөх ба бас тус тусын орон нутгийн баялагийн зэрэг зүйлийг боловсоноор ашиглан чадаагүйн учир санхүүгийн зүйлийг (58) их төлөв ард олны хөрөнгө малаас албан татвар ногдуулах хураах бөгөөд орон нутгийн захиргааны газруудын санхүүгийн хэргийг сайнаар явуулан чадаагүй, болохыг дурдваас элдэв албан хэргийг гүйцэтгэн явуулах албан хаагчдын орон тоо ба цалин хэрэглэлийг хэмнэн тогтоохыг хичээхгүй буюу хөрөнгө малын үнэн бүрэн тоог бүртгэн тодорхойлж албан татварыг нийлгэмчлэн явуулах ба мөн баян үгээгүйн байдалд тохируулах татварлах албан татварыг тогтоосон хэмжээгээр хураах (59) зэргийн чухал зүйлийг төдийлөн бүртгэн явуулсангүйн учраас албан татварын явдал ард олонд ихээхэн бэрхшээлтэй чирэгдэлтэй болсон газар маш үлэмж иймд орон нутгийн санхүүгийн явдлыг эмхлэн явуулах нь улсын чухал хэргийн нэгэн зүйл даруй мөн бөгөөд Засгийн газраас тогтоон явуулсан бодлого болвоос ард олны хөрөнгө малын чухам үнэн бүрэн тоог эрхбиш лавлан мэдэж албан үүргийг тэгшитгэн явуулах ба бас баян үгээгүй ялгаварлан мэдэж албан (60) татварыг өсгөх хөнгөтгөх зэргээр хохирол завшлийг нэгэн болгох албан хаагчдын орон тоог эрхбиш уг албан хэргийн байдал ба хүн амын үлэмж хомсыг харгалзан тогтоож арвилан хэмнэхийг чухалчлах мөн цалин хэрэгслийг тус газар орны байдалд тохируулан тогтоох элдэв албыг нэвтэлгэх салбар сум зэргийн өрхөөр дагнах албадыг бололцох байдалд нийлүүлэн, ард олонд чирэгдэл түвэгшээлгүй болгох зэргийн зорилт болгосон нь чухам ард олны зовлон зүдгүүр (61) -ийг нарийвчлан хянаж орон нутгийн санхүүгийн явдлыг эмхлэн тогтоох хэмээсэн чухал зүйл мөн. Энэ хэр ард олны албан татварын явдал болвоос зарим газар 40-50 мөнгө татварлаж буй, аваас нөгөө нэгэн газар 5-6 төгрөг хүртэл татварлаж бүхий. Энэ нь үнэхээрийн нийгэм тэгш үгүйгээр үл барам улсын ард нийтийн хохирох завших гэм харилцан чанга зөрүү болжээ. Бас, орон нутгийн захиргааны газрууд аливаа орлого зарлагын зүйлийг (62) ер урьдаас төсөвлөн мэдэж чадаагүй бөгөөд, хичнээн зарлага тохиолдвоос тэр тухай бүр албан татварыг оногдуулан дахин дахин хураах нь ард олонд туйлын бэрхшээлтэй хэрэг бөгөөд учир, юун хэмээвээс, нэг жилийн бүх зарлагыг сайнаар бүртгэн урьдаас төлөвлөж нэгмөсөн татварыг оногдуулахаас хэмжээ тогтоон хуваарилан хурааваас хүн бүр тохирох албан татварыг эртхэнээс мэдэж арга эрж гүйцэтгэх бөгөөд хохирон сүйтгэх явдалгүй хэдий тийн хэмээвээс нэгэнтэйгүүр (63) зарим аймаг хошуудын зарлага үлэмж зарим нь хомс энэ нь эртнээс нааш журамлан ирсэн заншил өөр буюу эсвэл явуулах хөдөлгөх албан хэргийн идэвх чанар харилцан адилгүй, зэргийн учир маш олон болох бөгөөд, хошуу хошуудын зарлага их бага янз бүр баймой. Бас хөрөнгө малаас татварлах албанаас бусад зүйлийн орлого хэмээвээс, мөн харилцан адилгүй жишээлбээс, нэгэн хошууны газар дэлхийн баялагийг

ашиглаж буй аваас зарим нь үгүй (64).

Улсын гааль татварын зэрэг орлогын зүйлийг зарим хошуу уг дүрэм хэмжээг ёсчлон явуулж, сайтар шаардан байцааж үлэмжхэнээр хурааж чадваас шийтгэх зүйл байх боловч зарим нь төдийлөн хөдөлгөн явуулаагүй зэргийн учраас ард олны хөрөнгө малаас татварлах алба хүнд хөнгөн нь харилцан адилгүй болох явдал хэзээ ч ирэх бөгөөд, энэхүү албан татварын хэргийг нэгэн мөр болгож нийгэмчлэн явуулах нь, туйлын чухал болжээ. Тэр аймаг хошуудын газраа орлого зарлагын данс тайланг нарийвчлан хянаж (65) боловсноор үйлдэн тухай бүр зохих дээд газруудад явуулж суулгах ба батлуулах зэргийн чухал явдал маш цалгар энэ зүйлийг тэр бүр бүтээн чадах боловсон хүнгүй буюу идэвх хичээл сайнгүй зэргийн үл болох ба нийлэлцэхгүй явдал маш олон нь санхүүгийн явдалд их л хортой болмой. Орлого зарлагыг урьд жилээс төсөвлөн бүтээж данс үйлдэх явдал орон нутгийн захиргааны газруудад төлөв үгүй мөн ч албан хэргийн байдлыг уг газрын хүчин хөрөнгө тэнцүүлэн явуулж чадаагүй ба (66) албан татварыг хөнгөн хөнгөтгөх хөрөнгө малын чухам тоог тодорхойлон гаргаж магадыг олж явуулах зэргээр ард олон албан үүргийг нийгэмчлэн явуулж завдаагүй нь чухамдаа орон нутгийн захиргааны газруудад санхүүгийн зэрэг хэрэг сайжран чадаагүй хэмээвээс болох бөгөөд, учир иймийн тул, аливаа орон нутгийн захиргааны газрууд өөр өөрийн орлого зарлагыг эрх үгүй барилцан урьдаас сайтар нарийвчлан төсөвлөж зохих дээд газраа батлуулан уг төсөвлөснөөс илүү зарцуулахыг (67) чухал болгох ба бас элдэвт арвилж хэмнэхийг гол болгож ард түмний чирэгдэл төвөгшлийг хорогдуулах мөн албан татварыг ногдуулахад баян чинээгээс улмаар өсгөн хураах ба, ядуу буурайгаас хөнгөтгөн хэлтрүүлэх зэргээр хохирол завшлыг нэгэн болгож хөрөнгө малын чухам үнэн тоог тодорхойлон авч албан үүргийг тэгшитгэх ба орлого зарлагын дансыг боловсон маягаар хөдөлгөж тайлан илтгэлээс тухай бүр гүйцэтгэн гаргаж харьяат дээд газруудад хянуулан батлуулах зэрэг явдлыг эрхбиш (68) чанартайгаар хөдөлгөн явуулж нэгэнтэйгүүр улсын санхүүг эрхлэх газраас нийт орон нутгийн зарлагыг хамтатган нэгэн газраа хэмжээгээр урьдаас татвар ногдуулж уудам хугацаанд цувруулан хурааж тус тусын харьяат газраа өөр өөрийн төлөвлөсөн дансны ёсоор тавин олгож зарцуулж болох ба аймаг хошуу бүр харилцан адил үгүй алба татварлах гэмийг ариутгах ард олны зовлон зүдгүүрийг нэгтгэх ба бас орон нутгийн захиргааны эрх баригчид түүгээр хэрэг тохиолдвоос тухай бүр алба татварыг зогсоох нь (69) чухал баймой.

Малын ажлын тухай

Манай улсын үндсэн хөрөнгө нь гагцхүү дөрвөн зүйлийн мал болох бөгөөд энэхүү малын байдлыг тодорхойлох, үндсэн хөрөнгө болох, мал нь ард түмний амьдарлага болох ба басхүү улсын аж ахуйг хөгжүүлэх явдалд гүнээ холбогдмой. Үүнд манай нутаг газар өргөн уудам хүн ард нүүдэллэн тархаж суух бөгөөд дөрвөн зүйлийн малыг ямагт бэлчээрт итгэж адуулан ажиллах нь цагийн улирлын хатуу зөөлний эрхэнд байх төдийгүй элдэв зүйлийн өвчин тахалын аюулаас (70) хамгаалах явдал сайн үгүй бас чоно зэргийн хорт араатны хөнөөгдлийг устгах арга хэрэглэсэн зүйлгүй зэрэг учраас малын үржих хомс харин ч үхэж хорогдох зэргийн хохирол сүйтгэл нь маш үлэмжхэн болмой. Тус улсын хөрөнгө малын тоо нь өнгөрсөн 16 онд тодорхойлсоныг баримталваас, адуу 1 сая 45 000, тэмээ 370 мянга илүү, үхэр 1 сая 740 мянга, хонь 9 сая 620 мянга, ямаа 1 сая 860 мянга, илүү болох бөгөөд, адуу (71) үхрийг нэжгээд, нэг тэмээ хоёр бод, долоон хонь нэг бод, 14 ямааг нэг бод хэмээн тус тус бодвоос бүгд мал нийлээд 5 сая 327 мянга илүү бод болмой. Энэхүү малын

чухам аль нь олон болох буй хэмээвээс хонь, ямаа зэрэг жижиг мал олонх болох ба, ер дөрвөн зүйлийн малын чухам алин нь тус ашиг үлэмжхэн буй хэмээвээс алин ч атугай ард түмний амьдарлага ба улсын аж ахуйн явдалд цөм туйлын их тустай хэдий тийм боловч харилцаанд шилэх сонгоход хүрэх аваас үхэр, хонь, адуу хэмээх зэргээр (72) дэс дараалан орох буй за. Ард түмэн дотор малын ажлыг гол болгож амьдрах нь бараг төлөв цөмөөр хэмээж болох боловч бас нэгэнтэйгүүр үзвээс үлэмжхэн малтай хөрөнгөлөг нь маш цөөхөн их төлөв малын жижиг ажилтан болмой. Малын жижиг ажилтан болвоос өөр өөрийн амьдралыг гүйцэтгэн буй амой. Малын их ажилтан хэмээх хөрөнгөлөг этгээд манай улсад төдийлөн олонгүй гагцхүү тус улсын байдалд тэнцүүлэн бодвоос хэрдээ хөрөнгөлөг хэдий тийн боловч энэхүү их ажилтан нь хөрөнгө малаас гарах (73) элдэв зүйлийн орлого зэргээр жижиг ажилтныг хохироулан мөлжих гэм мөн буй учир иймээс гадна дээр дурдсан бэлчээрийг ямагт итгэж адуулан ажилласны улмаас ард түмэн сүйтгэх зэргийн гэмийг тоочвоос маш үлэмж. Жишээлвээс, бороо ховор болохул даруй өвс ногоо ургац нэн тачир буюу зарим газар огт орохгүй зэргийн учраас ган гачиг тохиолдон малын тарга хүч олохгүй ба тэсгим хүйтний улирал цас үлэмжхэн унаваас малын идэш ховордож бас нэгэнтэйгүүр (74) өтөг бууц сайнгүй ус ховор зэрэг зүйлийн гэм шалтгаанаар мал үхэж хорогдох нь маш үлэмж тэр дээр тийнхүү ган зудын цагт өвс бэлчээрийг эрэн сонгон нүүсүгэй хэмээж уг малын тарга хүч сайнтай нь тууварлан явахад чадварлах мэт аваас бас нэгэнтэйгүүр турж эцсэн муу нь дагалдан чадахгүй байх бөгөөд, харсаар хөсөр гээгдүүлэн болохын учир харилцаанд таталдан харгалзаж асаар бүрмөсөн хохирон сүйдэх явдал байх ба бас охин мал нь (75) цөмөөр хээл олж чадахгүйн дээр хээл бүхий нь цагийн ган гачиг ба ус өвс бэлчээр бууц хэвтэш зэрэг үл тохирсоны уршгаас их төлөв дутуу төрж байх бөгөөд нийтдээ малын үржил их муу бас бүрийн зүйл зүйлийн өвчин нэн үлэмж бөгөөтөл арилгах хөнөөх арга эмчилгээний явдал угаас төдийлөн сайнгүй хэдий одоо аваас малын эмнэлгийн газрыг улсаас эхлэн байгуулсаар гурав дөрвөн жилийн нүүр болж буй боловч тус газрын хүчин хөрөнгө нимгэн тэр дээр (76) боловсронгуй эмч хүн цөөхөн бас олон ардууд эмнэлгийн ач тусыг сэнхрэн мэдсэн нь бага зэрэг зүйлийн учраас малын өвчнийг хамгаалах явдалд бага зэргийн тусыг үзүүлсэн боловч мөн л туйлд хүртлээ хөгжин чадаагүй үес болмой. Учир иймд малын ажлыг сайжруулан боловсоргдох нь тус улсын чухамхүү туйлын чухал хэрэг мөн. Үүнд малын ажлыг хэрхэн сайжруулах буй хэмээвээс дөрвөн цагийн улирлыг дагаж бэлчээрт итгэж адуулахыг эрхбиш зүй зохисоор өөрчлөн хадлан бордоо бэлтгэх бас хороо саравч байгуулваас (77) зохих боловч тус улсын газар нутгийн байдал харилцан адилгүй жишээлбээс хөвч хангай говь тал гэх мэт. Үүний ялгаа ямар буй хэмээвээс хангай газраа өвс ногооны ургац сайн, бас мод элбэг, хүн ард угаас сэлгүүцэн нүүдэллэх нь бага учир өвс хадаж бордоо тэжээл бэлтгэлийн хороо халхавч байгуулж болох мэт боловч говь тал газарт мод огт үгүй ба, ногооны ургац тачир бага ус нь ховор ийм ийм учраас олон ард нүүдэллэн шилжиж тархан нутаглах нь маш үлэмж иймийн тул өвс бэлтгэх ба хороо саравч бэлтгэх арга огт үгүй болох бөгөөд харин ч (78) нүүдэллэн одуулахгүй аваас үл болох нэн үлэмж, тиймийн тул өвс бордоо бэлтгэх явдлыг газар орны байдалд тохируулан зохих бөгөөд, жишээлбээс хөвч хангай газарт болвоос аль бололцоогоор өвс хадаж тэжээл бордоо бэлтгэх хэрэгтэй. Мөн тэр цөл говь модтой газар болвоос хороо саравч байгуулахыг хичээх хэрэгтэй. Говь тал газарт болвоос өвс хадлан үйлдүүлэх ба, пин саравч байгуулах аргагүй тул, аль өвс бэлчээр бүхий газрыг эрэн сонгоод нутагламой. Мөн малын өтөг бууц зэргээр хороо халхавч байгуулах

хэрэгтэй нэн ялангуяа говь газраа ус ховор болох нь малын ажилд (79), их л гэм болж буй учир, худаг ухах ба цас борооны усыг нэгэн дор хуралдуулах зэрэг ажлыг ямагт оролдвоос малын өвчин тахалын тухай, болвоос боловсон эмчийг сонгон хэрэглэх ба уг хэрэгт чадвартай боловсронгуй хүмүүсийг бэлтгэх энэ тухай хэргийг эрхлэн явуулах газрын хөрөнгө хүчийг зузаатган сайжруулахыг чухалчлах хэрэгтэй бас эл хэрэгт олон (80) ардыг удирдан танилцуулах явдал туйлын чухал болмой. Түүнээс гадна энэ мэтийн ажил явдлуудыг ард түмэнд ухуулан танилцуулж гүйцэтгүүлэх нь нэлээд бэрхтэй газар буй учир улсаас эрхлэн үлгэр үзэмжийн газар байгуулах зэргээр удирдах нь нэн чухал бас малаас гарах элдэв зүйлийн түүхий эд ба сүү тос зэрэг зүйлийг дотроо боловсруулах мөн боловсноор (81) ажиллахыг хичээх хэрэгтэй. Чоно зэргийн хорт араатныг сөнөөх аргыг сүвэгчилвээс зохимой хэмээжээ.

Довчин

Дэлхийн баялаг ба тариалан хадлангийн тухай

Байцааваас газар дэлхий болвоос цөм улсын хөрөнгө мөн бөгөөд энэ тухай хувийн өмч болгон үзэж үл болмой. Баялагийн зүйл хэмээвээс алт мөнгө зэс гууль тугалга эрдэнийн чулуу ой мод ан гөрөөс загас чулуун нүүрс зос шүү хужир давсны зэрэг зүйлүүд цөм багтмой (82). Энэхүү баялагийн зүйлийг боловсноор ашиглан ажиллах ба арчлан хамгаалах нь туйлын чухал хэрэг зүй нь энэ бүгдийн хэрхэн ашиглах хамгаалах зэрэг арга бодлогыг улсаас эрхлэн явуулбаас зохимой. Үүнд бидний улсын газар дэлхийн баялаг үлэмж хомс нь чухам ямар буй хэмээвээс зүйл бүрийн баялаг багагүй боловч хэдийнээс нааш боловсноор ажиллаж ашиглах байтугай арчлан хамгаалах арга замыг сайнаар бодолхийлэн явуулж чадсангүй (83). Жишээлвээс ой модны нэгэн зүйлийг хэлвээс, угаас ховор болох атал гал түймэрт шатаагдах буюу эсвэл хүн сүх хөрөөгөөр гам гэмгүй огтчин хядаж сүйтгэх нь тоолшгүйгээр үл барам ой мод үлэмжхэн хөвч газарт үслэг хэрэм булгын зэргийн ан шивээлэн орших бөгөөд, ийнхүү боловсноор арвилан хэмнэхийг бодохгүй болохул даруй, ой хөвчийн оронд халзан уул болж эрэг ганга (84) нурж элс шороо хийсээд ус булаг хатаж цас бороо тасалдан ган зуд шуурга шамрага үргэлж бууж ирэх ба ан гөрөөс ч аяндаан үгүй болмой. Иймд бусад зүйлийн баялагийг ашиглан хамгаалах зэрэг явдал цөм нэгэн болохоор барахгүй зарим нэгэн зүйлийг ашиглах ба арчлан хамгаалах явдлыг үүсгэн оролдлого үгүй нь маш үлэмж. Үлгэрлэвээс ядавч хужир давсны зэргийг боловсноор ажиллан ашиглах аваас гадаадаас (85) авчрахыг харж үлэмж үнээр худалдан авч хохирох гэмээс ангижрах болмой. Тийн атал энэ мэтийг ашиглах ба арчлан хамгаалахыг бодохгүй баймой. Чулуун нүүрсний нэгэн зүйлийг сайнаар хөгжүүлэн боловсноор ажиллан ашиглаваас ой модыг арчлан хамгаалж арвилан хэмнэх явдал аяндаа үүсч болох болмой. Бас хашаа байшин зэргийг чулуу туйпуу зэргээр үйлдвээс бат бэхээр үл барам мөн ой мод хамгаалах явдалд (86) тус үлэмж болмой. Ер баялагийн зүйлийг боловсноор ашиглан хамгаалахгүй болно. Нийтдээ улсын гарз ихээхэн болмой. Алт мөнгөний зэрэг баялагийг зүй нь сайнаар ажиллаж ашиглах нь чухал боловч энэ тухай урьдаар хөрөнгө шийтгэн ихээхэн орж сая тусыг олох бөгөөд улсын сангийн хөрөнгө хүчийг харгалзах хэрэгтэй. Одоо аваас манай улсын санхүүгийн зүйл нимгэн болох тул төдийлөн сайнаар хөгжүүлэн ашиглаж чадаагүй (87). Хэдий тийм боловч боловсноор ажиллах ашиглах нь чухал бөгөөд эрхбиш зүй зохисыг ирж ашиглан хамгаалахыг бодолхийлвээс зохимой.

Тариалангийн тухай болвоос манай улсын нутагт элдэв зүйл тариа тарьж болох тохирох газар

нэлээд байдаг мэт боловч Монголчууд эртнээс нааш өөрсдийн тариалан үйлдэж ашиг шимийг хөгжүүлэн чадсангүй дан ганц хөвч хангай нутгийн (88) хааяа зарим нэгэн хошуудын ардуудаас зөвхөн хувьсад хэрэглэгдэх төдий тариаланг үйлдэж буй мэт боловч сайнаар ажиллаж ашигласан нь бараг үгүй. Одоо аваас, дотоод гадаадын энгийн ард иргэн ба улсын сангаас тус тус эрхлэн үйлдэж буй хоёр янзын тариалан баймуй. Энгийн тариалангийн ажлын их төлөв нь хятадын харьяат нар болох бөгөөд тэд хэмээвээс цөм ашиг олохыг эрмэлзэн явуулж буй ба мөн газар шороо (89)-г арчлан хамгаалахыг огт бодохгүй болмой. Монголчуудын тариалах нь нэлээд мэт боловч тэдний их төлөв нь гадаадын хятад зэрэгт дам түрээслэн өгч ашиг хуваарь авах нь үлэмж, хааяа өөрсдөө эрхлэн үйлдэж буй нь дан ганц амьдралгыг гол болгон зөвхөн багаар оролдож байх төлөвтэй сангийн тариалан болвоос Хараа Орхон (90) Сэлэнгэ Ховд зэрэг газарт ажил үүсгэн явуулж буй боловч энэ хэр төдийлөн сайнаар хөгжин чадаагүй учир нь юу буй хэмээвээс энэ явдалд боловсронгуй хүмүүс ба, хүчин хөрөнгө хэрэгтэй бөгөөд тийнхүү боловсон хүмүүс ба, элдэв машин багаж тээрэм зэргийн хүнийг хүчийг бага хэрэглэх зэвсэг зүйл хүрэлцэж бүрдээгүй ба, мөн улсын сангийн (р.91) хөрөнгө нимгэний учраас ихээхнээр хөгжин сайжирч чадаагүй баймой.

Энэхүү улсын сангийн тариалан болвоос алин бүрийг боловсноор ажиллан явуулж олон ардад үлгэр дууриалын газар болгох нь их л чухал болмой. Нэгэнтэйгүүр жинхэнэ өөрсдийн тариалан үйлдэх монголчуудад дутагдах гачигдах багаж машин (92) мөнгө зэргийг улсын сан ба мөн улсын худалдаа үйлдвэрийн явдлыг эрхлэх банк мэтийн газраас туслан зээлдүүлж тэтгэн хөгжүүлэхийг чухал болгомой. Ер манай улсын дотор чухал хэрэглэгдэх тариа будаа гурилын зүйл маш үлэмжхэн бөгөөд мөн тариалж болох газар буй атал өөрсдөө тариалангийн хэргийг хөгжүүлэн ашиглах (93) үгүй дан ганц гадаадын харьяат нарын тариалах явдалд итгэх буюу мөн тариа будааны зүйлийг гадаадаас нэвтрүүлэн авчрахад шийтгэх нь үнэхээрийн зохилдохгүйгээр үл барам ашиг шимийг гадаадын гарт үлэмжхэнээр алдагдах хэрэг бөгөөд зүй нь буудай арвай будаа зэргийн идэх зүйл ба, бас олсны ... (хоосон зай) мэтийн эд боловсруулах (94) ургамлын зүйл малын идэх хиаг овьёос зэргийн тэжээл ихэд аваас аль нэгийг нь эрхлэл болгох тохирох газруудад өөрсдөө тариалж ажиллах явдлыг нийтээр шамдан оролдох ба мөн улсаас эрхлэн элдэв удирдлага тусламж үзүүлж хөгжүүлэх ба боловсон анжис хадуур машин цохих машин ган усан тээрэм зэргийн боловсон багаж зэвсэг үйлдэхийг (95) чухалчлах хэрэгтэй чадваас элдэв тариалангийн зүйлийг гадаадаас авч хэрэглэхгүй цөм дотроо боловсруулан бэлтгэх нь туйлын чухал баймой.

Бас хадлангийн явдал болвоос манай улсын газрын байдал аваас ногооны ургац харилцан адилгүй хангай говь тал янз бүрийн болох боловч тохирох газарт (96) хадлан хадаж малын тэжээл бэлтгэх явдлыг оролдож буй газар хэдийнээс нааш төдийлөн сайнгүй дан ганц Улаанбаатар хотын орчим газруудад бага сага хадлангийн ажил буй боловч бас л сайнаар ажиллаж ашигласан нь бага тэр дээр хадлангийн ажлыг оролдох жинхэнэ үйлдвэрийн хэрэгт мөн өөрсдийн оролдох нь цөөн ногоог хадсаны (97) хойно цагийг хожимдуулан хадсаны уршгаас өвсний чанар муу бөгөөд малын тэжээлд сайнгүй болох гэм буй мэт энэхүү хадлангийн ажлыг бага зэрэг оролддог газрууд болвоос их төлөв худалдаж ашиг олохыг эрмэлзэхээс бус малаа тэжээж хатуу хөшин цагийг өөрчлөх нь маш цөөхөн баймой. Иймийн тул хадлангийн ажлыг аль өвс (98) ногооны ургац сайнтай болох тохирох газар бүр эрхбиш санаачлан оролдож ажиллан наанадаж хувьсын малыг тэжээж цагийн хатуу догшиноос хамгаалан өөрчлөх ба чанадад харилцан худалдаалж аж ахуйн явдлыг хөгжүүлэх

нь чухал бөгөөд энэ тухай хэрэглэгдэх боловсон машин зэвсгийг бэлтгэж шамдан явуулваас зохимой.

Довчин (99)

Тээх нэвтрүүлэх явдал ба аж үйлдвэрийн тухай

Хянаваас манай улсын газар орон нь асар уудам хүн амьтан нь даанч цөөхөн хот балгад ховор бөгөөд хүн нэвтрэлцэх дардан дэргүүр зам зассан нь үгүй гол мөрөнд гүүргүй, намаг шавар газарт салгүй хол ойрыг холбож хэл мэдээ авалцахад хэрэглэх төмөр утас телефон ховор, захиа бичиг авалцах тогтмол шуудангийн өртөө үгүй иймийн тул аливаа албан ба амины буюу худалдааны хэргээр амархан нэвтрэлцэж үл болохын (100) харгаагаар мал тэрэг чарга хүний бие хичнээн өртөө сүйтгэхээс гадна, хичнээн өдөр сар гээгдэж буйг нь мөнгө болгож бодвоос эрхиш жил бүрт өдий төдий зүйл гарздан байх нь илэрхий бөгөөд, олон газрын нэвтрэлцэх хэргийг хүндэтгэн үзэж, муу замыг сайн болгох ба ус мөрөнд хөөрөг онгоц зэргийг байгуулах хийгээд төмөр телефоныг өргөнөөр байгуулах ба шуудан өртөө тогтоох мэтээр арвилан хуралдуулахыг чухалчлахын дээр одоо аваас бидний улс аливаа тээх нэвтрүүлэх зүйлийг гүйцэтгэх газрыг (101) тусгайлан байгуулсан нь хэдий удаагүй боловч энэ хэр уг газрын хөрөнгө гучин түм илүү төгрөг болох нь даруй уул зорьсон явдалд нэлээд тусыг буй хэмээхээр үл барам элдэв бараа юмыг нааш цааш, тээх нэвтрүүлэх явдал болвоос бидний улсад язгуураас онц хөгжүүлэн явуулсан газар төдий л үгүй. Дан ганц хааяа хүмүүс үхэр тэмээний зэрэг хөсөг хараахан хол ойр газар бараа юм тээх боловч тэд хүчийг нэгтгэсэн газаргүй зөвхөн өөр өөрийн (102) аж байдлыг харгалзан тус тусдаа ажиллах нь уг хэрэгт чанартайгаар тусыг хураан чадахгүй тэр дээр манай монголчууд хэдийнээс аж үйлдвэрийн явдалд дадамгай хүн үгүйн учраас жин тээвэрт уул ачааны хүнд хөнгөний хэмжээг баримтлан үнэ хөлс хэлэлцэхгүй төдийгүй тэмээний ачаа нэг бүр төчнөөн хөлс гэх мэт бүдүүлгээр хэлэлцэн гадаадын шунахай этгээдэд мэхлэгдэн мөлжигдөх гэм маш үлэмж. Ер эл тээх нэвтрүүлэхийн тухай ажил болвоос улсын худалдааны ба аж ахуйн явдлын чухал нөхцөл даруй мөн бөгөөд (103) зүй нь хэрхэн сайжруулах арга бодлогыг санаа талбин оролдож явуулваас зохих. Үүнд энэхүү тээх нэвтрүүлэх явдлыг эрхлэх газрыг тусгайлан байгуулсан нь бөгөөд, мөнхүү газарт уг хэргийг гүйцэтгэн явуулах онц эрхийг олгосон баймой. Иймийн тул харьяат газрыг идэвхтэй чанартай хөдөлгөн явуулахыг хичээвээс зохихын дээр эл явдалд хүн малын хүчийг хэмнэх бөгөөд хурдавчлах түргэлэх аргыг бодолхийлэн уурын тэрэг мэт машины зүйлийг аль болох зэргээр аж үйлдвэрийн тухай болвол манай (104) улсын ард түмэн аливаа урлах дархлах үйлдвэрийг хөгжүүлэн боловсруулсан нь болвоос сайнгүйн дээр нэн ялангуяа ойрноос эл аж үйлдвэрийн явдлыг огт чухалчлах үгүй агсан агсаар энэ хэр цөм хятад үйлдвэрийн иргэний гарыг харах болжээ. Унгас ноосоор эсгий хийх цэмбэ нэхэх, өөрсдийн өмсөж эдлэх дээл хувцас зэргийг өөрсдөө эсгэх оёх болоод, төмрөөр ирт мээ хийх мод чулуугаар гэр байшин барих, эмээл хом тэрэг тоног зэргийг өөрсдөө оролдвоос хийж чадах (105) бөгөөтөл цөм хятадын гараар хийлгэж өндөр үнээр худалдан авах болсон нь чухам сайнгүй шинж мөний тул эрхиш арга сүвэгчилж уран дарханы ажил үйлдвэрийг хөгжүүлвээс зохих үүнд, энэ тухай сургах удирдах зэрэг явдлыг сайнаар идэвхийлэн оролдож хүчийг нэгтгэх зэргээр улс төр ба, ард түмэн хийгээд амь биенд ч тусгүй ямар ба, ажил үйлдвэр үгүй хол явагчдыг чадах зохих ажил үйлдвэр хичээлгэх арга ирж тустай нэмэртэй явах болговоос зохихын дээр бас аливаа малын (106) ажлаас гарах түүхий эдийг боловсруулах ба газар дэлхийн баялагаас аль дөхмийг нь улсын

санхүүгийн хөрөнгө хүчнийг харгалзан ашиглах зэрэг ажил үйлдвэрийн явдлыг улсаас эрхлэн явуулваас зохимой. Учир юун хэмээвээс манай улсаас гадагш нэвтрэн гарах арьс шир ноос зэргийн түүхий эдийн зүйл маш үлэмжхэн болох атал, үүнийг боловсруулан хэрэглэх ч байтугай боловсноор ажиллаж туйлын үнийг хүргэж худалдаалан чадахгүй баймой. Жишээлбээс ноосны нэгэн зүйлийг гадаадын уг хэрэглэх газарт угааж цэвэрлэх нь болвоос онц (107) үнэтэй байх учир, тэрхүү ноосны хог бүртгийг угаан цэвэрлэж худалдваас юутай ашиг хөгжих билээ. Чадваас бас энэхүү зэргээр боловсруулж дотроо хэрэглэх ба нэвтрүүлэн худалдаалваас гадаадын шунахай худалдаачинд ахин дахин мөлжигдөх хонжигдохоос мултрахад юуны хол ажээ. Бас нэгэнтэйгүүр шир арьсны зүйлд аваад үзвээс үхрийн арьс нэгийг онц үлэмжээр бодвоос арван төгрөгөөр худалдан (108) хэдэн сарын хойно булигаар болгож авчрахад хорь буюу хорь илүү төгрөгөөр үнэлэн авч гутал хувцас үйлдэх жишээтэй баймой. Учир иймийн тул малын ажлаас гарах түүхий эдийн зүйлийг боловсноор ашиглаж боловсруулах нь маш чухал. Үүнд энэ хэр үүсгэж явуулсан аж үйлдвэрийн зүйл хэмээвээс булигаарын завод, үстэй дээл ба ботинк гутал үйлдэх газар ноос угаах тос хайлж саван лаа (109) үйлдэх ба гэдэсний ажлын газар буй. Хэдий тийн хэмээвч энэ мэт ажил үйлдвэрийг санасан төдийгөөр бүтээх нь бус, эрхиш уг ажилд боловсорсон хүн ба хөрөнгө чухал холбогдмой. Тэр дээр язгуураас Монголын жинхэнэ хөдөлмөрчингүй зэрэг зүйл зүйлийн учраас хөгжүүлэн байхад бэрхтэй төвөгшөөлтэй газар маш үлэмж (110). Мөн эдүгээ үүсгэн байгуулахыг завдан буй үйлдвэрийн ажил хэмээвээс модны завод цэмбэ нээх завод төмрийн завод туйпууны завод зэрэг ихээхэн ажил үйлдвэрийн газруудыг нээн байгуулахаар завдаж аливаа хэрэглүүнийг төлөв бүртгэн баймой. Бас газар дэлхийн баялагийг ашиглах үйлдвэр хэмээвээс алт малгах тэмтрэх ба эрдэнийн чулуу чулуун нүүрс зэргийн ажлыг үүсгэн буй боловч мөн боловсон хүн хөрөнгө (111) хүч өөрийн хөдөлмөрчин зэрэг зүйлүүд бүртгэн чадаагүйн учраас сайнаар хөгжүүлэн чадсан хэмээхэд нэн бэрх хэдий тийм боловч зүй зохисыг үзэж боловсон арга хэрэглэж хөгжүүлэн явуулахыг бодолхийлсээр буй энэхүү дээр заасан түүхий эд боловсруулах явдал ба аж үйлдвэрийн явдал хэмээвээс чухамхүү улс төрийн явдлыг бататгах чухал зүйл даруй мөн бөгөөд, нийтээр санаа талбин (112) чармайн оролдвоос зохих үндсэн хэрэг хэмээвээс болох ба мөн ч эдгээр аж ахуйн явдлыг чанартайгаар хөгжүүлэн бадруулваас аяндаан улсын орлого бат нот болж урагш давших нь лавтай болмой.

Довчин

Тус улс худалдааны байдал ба харилцан туслалцах хоршооны зорилгын тухай

Байцааваас худалдааны явдал хэмээгч даруй улсын эдийн засгийн явдлыг хөгжүүлэн бататгах хэрэгт (113) гүнээ холбогдох зүйл мөн бөгөөд, улсаас эрхлэн мэдэж явуулах нь маш чухал болмой. Үүнд тус улсын худалдааны байдлыг өгүүлвээс, манай монголчууд язгуураас худалдааны үйлсэд тогтомгүйн учир, тус улсын харьяат бие даалгасан худалдааны хэрэг эрхлэгчид уулаас байсангүй, дан ганц аар саар худалдаачин байх мэт боловч тэд улсын дотроос гарсан түүхий эдийг туйлын газар хүргэж худалдаалах ба ард (114) түмний чухал хэрэглэх бараа зүйлийг жинхэнэ боловсорсон газраас үнэлэн авч нэвтрүүлэн авчирч чадахгүй болох нь чухамдаа гадаадын шунахай худалдаачинд туслах нөхцөл болохоос зайлах газаргүй болой. Учир тиймд улсын худалдааны явдлыг хэн эрхэлсэн буй хэмээвээс цөм гадаадын шунахай улсын худалдаачны эрх мэдэлд буй хэмээвээс зохимой. Манай (115) улсад жил бүр гаргах аливаа малын унгас ноос арьс шир ангийн үс зэрэг түүхий эдийн

зүйл маш үлэмж боловч тэдгээрийг дотроо боловсруулж өөрсдөө хэрэглэж чадахгүйн учраас цаг ямагт гадаадад гарч одох бөгөөд түүнийгээ авч ирмөй хэмээвээс дээр хэлсэн ёсоор гадаадын шунахай худалдаачин нэвтрүүлэн авчирч буй нь (116) уг түүхий эдийн зүйлийг Монгол газраас авахдаа үнэ үлэмж будах эсгэх зэрэг явдал цөм тэдний зоригт болох ба бас ч ард түмний чухал хэрэглэх эд барааны зэрэг зүйлийг мөнхүү гадаадын худалдаачин авчирч дэлгэрүүлэх бөгөөд тэд нар уул юмны үнийг өндөр болгож худалдаалж ашиглах явдал маш өрнөсөн хэмээвээс болохын дээр уг эд бараагаар түүхий эдийг (117) арилжаалан сольж авахдаа үнийг үлэмж хомс болгон бодож ард олныг төөрөгдүүлэх ба дашрамд хэмжээ жигнүүрээр гэнэдүүлэн мөлжих мэхлэх зэргээр давхар давхар хожих гэмийг тооловч барахгүй болжээ. Жишээлбээс нэгэн зах нарийн даалинбын уг үнэ хоёр янчаан болох аваас худалдаалах хятад даруй гурван янчааны үнэ зохион хонины ноос жин бүрийг (118) хорин мөнгөөр бодож арван таван жин ноосноос өгсөн уул ноосыг туйлын газарт жин бүр дөчин мөнгөний үнээр худалдааас нэгэн даалинбаас даруй гурван янчаан хонжих болох төдийгүй басхүү харилцан худалдаалахад даалинбыг татах амлах ба унгасыг хатуу жигнүүрээр хэмжих зэргээр давхар мөлжих гэм буй мэтийн төлөвтэй баймөй. Учир иймд энэхүү (119) худалдааны явдлын тухай ард түмний гадаадын шунахай худалдаачны гараас ангижруулахыг эрмэлзэхүй чухамхүү улсын засгийн чухал бодлого мөн болох бөгөөд үүнд ард түмний гадаадын шунахай этгээдийн гараас ангижруулах зам ямар буй хэмээвээс улсын гадаад худалдааны хэргийн зүй зохисыг үзэж улсын онц эрх (120) болгон явуулах ба дотоод худалдааны хэмжээ загварыг тогтоож тэгшитгэн сайжруулах хэргийг мөн улсаас эрхлэн удирдах ард түмний хөрөнгө хуралдуулан хоршоолсон ажлыг тэтгэн хөгжүүлэх зохих гол газруудад яармаг хэмээх худалдаа байгуулах гагцхүү түүхий эдийн зүйлийг боловсруулах ба үйлдвэрийн хэргийг хөгжүүлж (121) аж ахуйн хэргийг бататган сайжруулах зэрэг зүйлүүд чухал холбогдмөй. Улсын гадаад дотоод худалдааны явдлыг улсаас эрхлэх нь тус улсын байдалд тохируулан нэгэн зам мөрийг олж явуулахад дөхөм болгохын учир болой. Ард түмний хөрөнгийг хуралдуулан хоршоолсон ажлыг тэтгэн туслах нь (122) ер хувийн хөрөнгийг эрхлэгчид тус тусдаа эл явдлыг эрхлэх ахул цөм өөрсдийн ашиг тусыг хөгжүүлэхийг хичээх учир ард түмний эрх ашигт хорлолтой болох бөгөөд тийнхүү ард олноор хөрөнгө хуралдуулан хоршоолж ажиллах нь уг ажил явдлыг эрхлэн явуулахад хүчин нэгдэж хөрөнгийг зузаатган ард нийтээр ашиг тус үзэх болмөй (123). Бас худалдааны явдалд түүхий эдийг боловсруулах явдал ба үйлдвэрийн хэргийг хөгжүүлэх нь ямар учир буй хэмээвээс түүхий эдийг үлэмжхэнээр боловсруулан басхүү элдэв уран дарханы үйлдвэрийг хөгжүүлэн ард түмний аливаа хэрэглүүнд гадаадаас авчрах явдлыг итгэн суух явдал (124) аяндаа хомсдох учир, гадаадын худалдаачны зүйл зүйлээр мөлжих гэмээс мултрах замын нэгэн ихээхэн судал болмөй. Манай улсад гадаадаас авчрах эд бараа ба, мөн гадаадад тээн гаргах түүхий эд зүйлийн алин нь илүү буй хэмээвээс ойрх хэдэн онд гадаадаас ирэх зүйлийн үнэ баахан дутуу мэт төлөвтэй байдаг. Ер энэ зүйлийн аль нь илүү байваас улсын эдийн засгийн хэрэгт сайн буй хэмээвээс гадагш гаргах зүйлийн үнэ бага зэрэг илүү байваас (125) сайн болох мэт Ардын Засгийг байгуулснаас нааш шунахай худалдаачдад дуустлаа бүү идэгдсүгэй хэмээн Ардын харилцан тусалцах хоршоо байгуулсан бөгөөд, харьяат хоршооны зорилго болвоос тус улсын түүхий эд зүйлийг уул газарт хүргэж зохих үнээр худалдах ба ард түмний чухал хэрэглэх зүйлийг чухам боловсруулан буй газраас хямд хялбар үнээр авчрах ард олны дунд дэлгэрүүлэх зэргээр гадаадын шунахай

хөрөнгөтний (126) мөлжигдлөөс ангижрахыг чухал бодлого болгосон нь хүлээсэн үүрэг үнэхээрийн хүнд энэ завсар харьяат хоршооны хэрэг явдал жил ирэх тутам улмаар хөгжин дэлгэрч ард түмэнд үлэмжхэн тусыг үзүүлж буй тус хоршооны хөрөнгө хэмээвээс, их төлөв нь улсын санхүү оруулсан хувь мөнгө ба, гишүүдийн нийлүүлсэн хувь зэрэг бөгөөд, энэ хэр найман сая гаруй төгрөгийн гүйлгээтэй элссэн гишүүдийн тоо болвоос зургаан мянга илүү хэлтэс салбар гучаад майхны худалдаа дал шахам (127) болжээ. Харьяат улсын бүх худалдааны гүйлгээг дөрвөн хувь болгон бодвоос Харилцан туслалцах хоршоо нь, даруй нэгэн хувийг гартаа авч чадсан хэмээвээс зохимой. Үүнд тус хоршооны хэрэг явдлыг сайнаар явуулж гадаадын шунахай хөрөнгөтний гараас гарах хэрэг тийм амархан бус эрхбиш худалдааны явдалд боловсорсон хүмүүс ба хөрөнгө мөнгө ихээхэн хэрэгтэй бас гадаадын аль нэгэн чухал харилцах газарт салбар (128) ангийг байгуулж холбоог тогтоох нь маш чухал тэр дээр харилцах этгээдийн түгшүүртэй амгалангийн байдалд гүнээ холбогдмой.

Хоршоо болвоос олон жижиг гол нийлж нэгэн ихээхэн мөрөн болох мэт олон жижиг хоршоолсон ажлыг удирдан нэгтгэж холбох шижмийн газар мөн бөгөөд үүнд олон аймаг хошуу хотын зэрэг орон нутгийн газруудад тус тус нутгийн хоршоо байгуулах явдал туйлын чухал болмой. Тэрхүү нутгийн хоршоог (129) хэрхэн байгуулах ба энэхүү Харилцан туслалцах хоршоо лугаа хэрхэн харилцаж удирдуулах буй хэмээвээс нутаг нутгийн ардууд элсэн хувь оруулж хоршоо байгуулан тус нутгийн худалдааны явдлыг өөрсдөө эрхлэн мэдэж явуулмой. Түүний ач тус юун буй хэмээвээс нутгийн ардууд болвоос, хоршоолсон хоршоо болвоос, тус газар орны байдалд тохируулан хэрэг ажлыг явуулахад маш дөхөмтэй баймой (130). Тэдгээр нутгийн хоршоодоор харьяат газар оронд чухал хэрэглэгдэх эд бараа юу болохыг урьдаас тодорхойлон Харилцан туслалцах төв хоршооноо мэдүүлж хүлээн авч ард түмэнд улмаар зарцуулах ба, өөрсдийн худалдаж авсан түүхий эдийн зүйлийг мөнхүү Харилцан туслалцах төв хоршооноо хүргүүлж уламжлан зохих газарт худалдуулах болмой (131).

Харилцан туслалцах төв хоршоо болвоос харьяат олон нутгийн хоршоодын хэрэг ажлыг хянан харгалзаж ерөнхийд удирдан бүхий улсын дотор хэрэглэгдвээс зохих эд бараа зүйлийг туйлын газраас хялбар үнээр авчирч нутгийн хоршоонд тархаан өгч худалдуулах ба мөн тэдний улс түүхий эд зүйлийг туйлын газарт үнэ хүргэн худалдаалах зэрэг гадаадын худалдааны явдал эрхлэх болмой. Иймийн тул хоршооны явдлыг ард нийт чухал болгон үзэж (132) гишүүн элсэж хувь мөнгө оруулан хөрөнгийг зузаатган хүчийг нэгтгэн уг хэрэг явдалд идэвхтэй оролцож сайжруулах гадаадын шунахай хөрөнгөтөн лүгээ эсэргүүцэж ард түмнийг тэдний мөлжигдлөөс ангижруулах явдалд чармайн оролдох явдал туйлын чухал болмой.

Багш Довчин (133)

Монгол улсын арван долдугаар он, таван сарын хорин таван

Чойлон (134)